

Сайншанд – Цагаан суварга чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөл

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн

2025 ОНЫ 12 ДУГААР САР



Сайншанд – Цагаан суварга чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөл

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн Environmental and Social Impact Assessment (ESIA)

Гүйцэтгэсэн	Adam Khan
Шалгасан	Энхтулга Төмөрбаатар
Хянасан	Katie Prebble
Баталсан	Rachael Bailey
Баримт бичгийн лавлагаа	30271256
Огноо	12-P CAP 2025

Хувилбарын хяналт

Хувилбар	Огноо	Гүйцэтгэсэн	Шалгасан	Хянасан	Баталсан	Өөрчлөлтүүд
01	01 August 2025	AK	ET	KP	RB	
02	December 2025	AK	ET	KP	RB	ЕСБХБ-ны шүүмжийн дагуу

Агуулга

Товчлол	6
1 Танилцуулга	8
2 Төслийн тодорхойлолт	15
3 Төсөлд авч үзсэн хувилбар	57
4 Хууль, стандарт, бодлогын орчин	64
5 БОНИНУ-г хэрэгжүүлэх арга зүй	114
6 Талуудын оролцоог хангах	126

Хүснэгтүүд

Хүснэгт 1-1 БОНИНУ-ний баг	12
Хүснэгт 1-2 Техникийн мэргэжилтэн	13
Хүснэгт 1-3 БОНИНУ тайлангийн бүтэц	13
Хүснэгт 2-1 ЦДАШ-ын маршрут ба дамжин өнгөрөх сумд	23
2-2 Төслийн маршрут ба орон нутгийн дэд бүтцийн огтлолцол	25
Хүснэгт 2-3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурууд	31
Хүснэгт 2-4 Монгол Улсын цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвас	37
Хүснэгт 2-5 Баганын суурийн үзүүлэлтэд үндэслэсэн ухагдах материалын хэмжээ	52
Хүснэгт 2-6 Төслийн хэрэгжүүлэгч болон холбогдох эрчим хүчний байгууллагууд	56
Хүснэгт 4-1 ЕСБХБ-ын Гүйцэтгэлийн шаардлагууд болон тэдгээрийн төслийн холбогдох байдлын хураангуй	65
Хүснэгт 4-2 Монгол Улсын нэгдэн орсон олон улсын байгаль орчны болон соёлын өвийн конвенцууд	76
Хүснэгт 4-3 Монгол Улсын соёрхон баталсан ОУХБ-ын конвенцууд	79
Хүснэгт 4-4 Байгаль орчин, нийгмийн гол хуулиуд	83
Хүснэгт 4-5 БОНУ явц	99
Хүснэгт 4-6 Төсөлд хамаарах Монгол улсын байгаль орчны үндэсний стандартууд (MNS)-ын жагсаалт	109
Хүснэгт 4-7 Төсөлд хамаарах Монгол улсын эрчим хүчний стандартууд (MNS)-ын жагсаалт	111
Хүснэгт 4-8 Төсөлд хамаарах Монгол улсын эрчим хүчний барилгын норм, дүрмийн жагсаалт	112
Хүснэгт 5-1 Нөлөөллийн хэмжээг тодорхойлох жишээ тайлбар	120
Хүснэгт 5-2 Хүлээн авагчийн мэдрэмтгий байдлыг тодорхойлох жишээ тайлбар	122

Хүснэгт 5-3 Нөлөөллийн эрчим, цар хүрээний ач холбогдлыг үнэлэх	123
Хүснэгт 6-1 Оролцогч талууд, нөлөөлөл, сонирхол ба нөлөө	129
Хүснэгт 6-2 Харилцааны аргууд	133
Хүснэгт 6-3 Оролцогчдын санаа зовнил, санал бодлын тойм	135
Хүснэгт 6-4 Талуудын оролцоог хангах хөтөлбөр	137

Зургууд

Зураг 1-1 Төслийн байршил	9
Зураг 1-2 БОНИНУ-ний мэдээллийг ил болгох багцын бүтэц	11
Зураг 2-1 Монгол Улсын цахилгаан түгээх сүлжээ ба дамжуулах системүүд (ТЭХС шар өнгөөр тэмдэглэсэн)	16
Зураг 2-2 ТЭХС-ийн өдөр тутмын цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт ба эрэлт	18
Зураг 2-3 ТЭХС-ийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугамууд	19
Зураг 2-4 ТЭХС-ийн дамжуулах шугамууд	21
Зураг 2-5 Төслийн маршрут ба орон нутгийн дэд бүтэц	26
Зураг 2-6 ЦДАШ-ын трасс болон ойролцоох суурин газрууд	29
Зураг 2-7 Тататлын тулгуурууд	32
Зураг 2-8 Тулгуурын суурийн техникийн үзүүлэлтүүд	32
Зураг 2-9 Тулгуурын суурийн төлөөлөх загварчилсан угсралтын зураг	33
Зураг 2-10 Сайншанд дэд станцын байршил	34
Зураг 2-11 Цагаан Суварга дэд станцын байршил	35
Зураг 2-12 ЦДАШ-ынэ трассын дагуух газар ашиглалт	41
Зураг 3-1 Санал болгож буй маршрутын шугамын өөрчлөлт	60

Хавсралт

Хавсралтууд – тусдаа ботийг үзнэ үү.

Товчлол

Товчлол	Тодорхойлолт
НБ	Нөлөөллийн бүс
CBO	Community-Based Organisations
ТЭХС	Төвийн эрчим хүчний систем
CHP	Combined Heat and Power
CITES	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц
CIEEM	Chartered Institute of Ecology and Environmental Management
CSO	Civil Society Organisations
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ЦСО	Цахилгаан соронзон орон
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
БОНУ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОНиНУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНБ	Байгаль орчин, нийгмийн бодлого
БОН	Байгаль орчин, нийгэм
FAO	Food and Agriculture Organisation of the United Nations
FIDIC	International Federation of Consulting Engineer
GDP	Gross Domestic Product
БОНЕУ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
GIP	Good International Practice
GW	Gigawatts
ӨС	Өрхийн судалгаа
ШЧГ	Шувуудад чухал газар
ILO	International Labour Organisation
IUCN	International Union for Conservation of Nature
KIS	Key Informant Interviews
km	Kilometre
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

MNT	Mongolian Tugriks
ЭХЯ	Эрчим хүчний яам
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ХҮ	Хяналт, үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
NO ₂	Nitrogen Dioxide
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ДШЭХА	Дуу шуугиан эмзэг хүлээн авагч
ХЭМАА	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
O&E	Operation and maintenance
PIR	Public Information Policy
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
РМ	Жижиг ширхэг тоосонцор
ГШ	Гүйцэтгэлийн шаардлага
ХЗ	Хамгаалах зурвас
SEA	Састэйнабилити ийст эйжия
ТОХТ	Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
SNH	Scottish National Heritage
SO ₂	Sulphur Dioxide
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
УБ	Улаанбаатар
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
НҮБ/АӨСК	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
USDA	United States Department of Agriculture
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
WSCCM	Wildlife Science and Conservation Centre of Mongolia


1 Танилцуулга

1.1 Оршил

- 1.1.1 Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ) нь Монгол улсын Засгийн газарт Дорноговь аймагт 204 км урт хоёр хэлхээт 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) барих төслийг санхүүжүүлэх зорилгоор засгийн газрын зээл олгох асуудлыг авч үзэж байна. Энэхүү трассын чиглэл нь Сайншандад төлөвлөгдсөн дэд станц (Чойр - Сайншанд ЦДАШ төсөл)-аас холбогдсоноор эхэлж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (ЦДҮС)-ийн ашиглалтад байгаа Цагаан суваргын уурхайн ашиглалтын талбай дотор байрлах 220/35/22 кВ дэд станцтай холбогдсоноор дуусна. Тус 204 км урттай ЦДАШ, дэд станцын холболтыг "Төсөл" гэж нэрлэсэн.
- 1.1.2 ЕСБХБ-аас Аркадис (Их Британи) Консалтинг Лимитэд болон дэд зөвлөх Экотрэнд ХХК-тай хамтран Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОНИНҮ)-г хийх даалгавар авсан болно. Үүнд ЕСБХБ-ны 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ), Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)-тай харьцуулан байгаа мэдээллийг шүүмжлэлтэйгээр хянах, зөрүүг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд ЕСБХБ-ны шаардлагыг хангах үүднээс холбогдох мэдээллийг нэмэлтээр баяжуулах зэрэг ажлууд багтсан болно. Энэхүү баримт бичиг нь төслийн БОНИНҮ-ний тайланг танилцуулж багаа бөгөөд Энэхүү баримт бичиг нь БОНИНҮ-г танилцуулж байгаа бөгөөд ЕСБХБ-ны мэдээллийг ил болгоход тавигдах шаардлагыг хангах зорилгоор бэлтгэгдсэн хэд хэдэн баримт бичгүүдийн нэг хэсэг болно:
- Техникийн бус хураангуй (ТБХ)
 - Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)
 - Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТ)
 - Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээ (ГЧНШХХ)
 - Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ)
- 1.1.3 Олон нийтийн хэлэлцүүлгийн хураангуй тайланг мэдээлэл нийтэлсний дараа бэлтгэнэ.
- 1.1.4 2021 онд Эрчим хүчний яамны захиалгаар Мастер пойнт ХХК-аас боловсруулсан "Сайншанд – Цагаан суварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын нарийвчилсан инженерийн зураг төсөл"-ийн нарийвчилсан зураг төслийг энэхүү тайланд тусгасан болно.

1.2 Төслийн орчин

- 1.2.1 Монгол улсын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулах сүлжээ нь дөрвөн бие даасан эрчим хүчний системээс бүрддэг бөгөөд энэхүү төсөл нь Төвийн бүсийн эрчим хүчний Систем (ТЭХС)-д хамаарна. Төслийн талбайн байршлыг дараах **Зураг 1.1**-т зурагт үзүүлэв. Төсөл нь Дорноговь аймагт байрлах бөгөөд Чойр–Сайншандын агаарын шугамын төслийн хүрээнд баригдаж буй Сайншандын 220/110/35 кВ-ын шинэ дэд станцаас эхэлнэ. ЦДАШ нь баруун өмнө зүгт чиглэн Сайншанд, Улаанбадрах, Сайхандулаан, Мандах гэсэн дөрвөн сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч Цагаан суварга дахь 220/35 кВ-ын дэд станцад холбогдоно.



Зураг 1-1 Төслийн байршил

- 1.2.2 Ерөнхийдөө цахилгаан дамжуулах шугамын төлөвлөсөн трасс нь хүн ам цөөн суурьшсан бүсээр дайран өнгөрөх бөгөөд Говь цөлийн ургамлын шинж чанарыг агуулсан байна. Хамгийн ойрын байнгын суурин нь Сайншанд (ойролцоогоор 4.4 км), дараа нь Зүүнбаян болон Мандах нь тус тус төслийн трассаас ойролцоогоор 26 км ба 43 км зайтай байрладаг. Зүүнбаяны ойролцоо (төслийн трассаас 22 км) Оюутны цэргийн сургалтын төв байна.

- 1.2.3 Дорноговь аймаг нь Улаанбаатар хоттой А0101 болон А0102 хатуу хучилттай авто замаар холбогддог бөгөөд эдгээр нь Азийн 3-р автозам (АА3)-д хамаарагддаг. АА3 нь Монгол Улсын хойд хил дээрх Оросын Алтанбулаг боомт болон өмнөд хил дээрх БНХАУ-ын Замын-Үүд боомтыг холбодог. Аймгийн төв болон сумдын төвүүд хатуу хучилттай замтай боловч төслийн сумууд хоорондоо хатуу хучилттай зам (АА3 дагуух сумууд) болон шороон замаар (Сайншандаас бусад аймгийн төвүүд рүү) холбогддог. Төслийн трасс руу шууд явах хатуу хучилттай зам байхгүй.
- 1.2.4 Транс-Монголын төмөр зам нь Орос, Хятад улстай чухал нийгэм-эдийн засгийн холбоог бүрдүүлдэг бөгөөд Оросын Улаан-Үүд хотоос эхэлсэн Транс-Сибирийн төмөр замыг Монголын нийслэл Улаанбаатараар дамжин Хятадын Эрээн, Бээжин хотуудтай холбодог. Энэ шугамын Монголын хэсэг нь нийт 1,110 км урттай. Мөн Дорноговь аймгийн Сайншанд хотыг Алтанширээ сумтай холбосон 27 км урттай үйлдвэрийн зориулалттай төмөр зам баригдсан бөгөөд энэ нь Алтанширээ суманд баригдаж буй Монголын газрын тосны үйлдвэрийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

1.3 Төслийн зорилго

- 1.3.1 Төслийн зорилго нь Улаанбаатар-Багануур-Чойрын шугам, Чойр-Сайншандын шугам (одоогийн байдлаар барилгын өмнөх шатанд байгаа), Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюу Толгой-Цагаан Суваргын коридорын хооронд холбогдсон тойрог бүхий системийг бүрдүүлснээр дугуй хэлбэрийн дамжуулах сүлжээг бий болгоход оршино. Улмаар говийн бүс нутгийн цахилгаан хангамжийн найдвартай, тэсвэртэй байдлыг мэдэгдэхүйц сайжруулахад чиглэнэ.

1.4 Захиалагч

Commented [BE1]: Зөв ү

- 1.4.1 Эрчим хүчний яам (ЭХЯ) нь төсөл хэрэгжүүлэх байгууллага байна. ЭХЯ нь Монгол улсын эрчим хүчний бодлого, холбогдох дэд бүтцийн хөгжлийг хариуцдаг бөгөөд энэхүү төслийн хүрээнд төсөл санаачлагч байгууллага юм. ЭХЯ нь ЕСБХБ болон зөвлөхүүдтэй зохицуулалт, харилцаа холбоог хариуцан төв цэгээр ажиллах төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) байгуулсан бөгөөд одоогийн хэрэгжүүлж буй Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөлтэй холбоотой болно. Уг ТХН нь 2025 оны эцэст татан буугдах боловч 2026 онд шинэ ТХН байгуулна. Энэхүү төсөлд ТХН шаардлагатай байх төлөвтэй бөгөөд ЕСБХБ-ны төслүүдийн хэрэгжилтийн залгамж, чанарыг хангах, өмнөх туршлагаас суралцах үүднээс Чойр-Сайншандын төсөлд ажилласан мэргэжилтнүүдийг дахин оролцуулах нь хамгийн тохиромжтой гэж үзэж байна.
- 1.4.2 Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК (ЦДҮС) нь улсын өмчит цахилгаан дамжуулах байгууллага бөгөөд Монгол улсад ашиглагдаж буй 22 кВ, 35 кВ, 110 кВ болон 220 кВ-ын дэд станц, агаарын цахилгаан дамжуулах шугамын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцдаг бөгөөд цахилгаан дамжуулах агаарын шугамыг дэмжих 84 дэд станцын сүлжээг удирдан зохион байгуулдаг. ЦДҮС төслийн үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

1.5 ЕСБХБ-ны төслийн шаардлага

- 1.5.1 ЕСБХБ-ны 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ) нь байгаль орчин, нийгмийн судалгаа, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын оролцооны мөн чанар, түвшинг тодорхойлохын тулд төсөл бүрийг ангилдаг (А, В эсвэл С). Энэ нь төслийн шинж чанар, байршил, мэдрэмтгий чанар, цар хүрээ, мөн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй шинэ бөгөөд нэмэлт нөлөөллийн хэмжээтэй уялдсан байна. Төслийн холбогдох одоо байгаа байгууламжуудтай холбоотой өнгөрсөн болон одоогийн байгаль орчин, нийгмийн асуудал, эрсдэлүүд нь ангиллаас үл хамааран байгаль орчин, нийгмийн үнэлгээнд хамрагдана.
- 1.5.2 2019 оны БОНБ-ын Хавсралт 2-ын дагуу ЕСБХБ нь төслийг ангилахдаа “Ногоон талбай”-д төлөвлөгдсөн бүтээн байгуулалт болон “өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралт”-д хамаарах тул А ангилалын статуст оруулсан болно. Тус ангиллын шаардлагын дагуу иж бүрэн БОНИНУ боловсруулж, холбогдох баримт бичгүүдийг нарийвчлан боловсруулж, хянах шаардлагатай. Мөн ЕСБХБ-ны 2019 оны Мэдээлэлд хандах журмын дагуу төсөл нь засгийн газрын секторын төсөл тул 120 хоногоос багагүй хугацаанд мэдээллийг ил болгох шаардлагатай.

1.6 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

- 1.6.1 Энэхүү БОНИНУ-ний зорилго нь төслийн бүх үе шатанд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг системтэйгээр тодорхойлох, эдгээр нөлөөллийг бууруулах, эсвэл бүрэн зайлсхийх арга хэмжээг хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулах, тогтооход оршино. Энэ БОНИНУ нь ЕСБХБ-ны 2019 оны БОНБ болон ГШ-тай нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд доорх **Зураг 1-2** заасны дагуу бусад баримт бичгүүдийн хамт олон нийтэд ил тод мэдээллэх болно.



Зураг 1-2 БОНИНУ-ний мэдээллийг ил болгох багцын бүтэц

- 1.6.2 ГШ нь мөн Европын холбоо (ЕХ)-ны үндсэн стандартуудыг мөрдөх шаардлагатай байдаг.Үүнд:

- 2014/52/EU – БОНУ-ний удирдамж;
- 2000/60/EC – Усны хүрээний удирдамж;

Commented [BE2]: The EIA Directive

- 2008/98/EC – Хог хаягдлын хүрээний удирдамж;
- 2009/147/EC – Шувуудын удирдамж;
- 92/43/EEC – Амьдрах орчны удирдамж;
- 2024/2881/EC – Европын орчны агаарын чанар, цэвэр агаарын удирдамж;
- 2013/35/EU – Ажилчдын биет хүчин зүйлсийн (цахилгаан соронзон орон) эрсдэлд өртөхтэй холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгийн доод хэмжээг тогтоосон шаардлагын удирдамж;
- Directive 89/391/EEC – Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгийн доод хэмжээг тогтоосон шаардлагын удирдамж.
- 89/654/EEC – Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгийн доод хэмжээг тогтоосон шаардлагын удирдамж.

Commented [EM3]: Habitats directive?

Commented [KP4R3]: Yes, now added

1.6.3 Монгол улсын зохицуулалт нь ГШ болон ЕХ-ны үндсэн байгаль орчин, нийгмийн стандартуудаас ялгаатай байх тохиолдолд төслийг илүү хатуу шаардлагыг хангах түвшинд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. Холбогдох стандарт, хууль тогтоомж, бодлогын талаарх дэлгэрэнгүйг **4-р бүлэгт** тусгав.

1.7 БОНИНУ-ний баг

1.7.1 БОНИНУ-ний баг нь Аркадис, Экотрэнд болон Оушн Ревайв компанийн мэргэжилтнүүдээс бүрдсэн бөгөөд үндсэн БОНИНУ-ний багийг Хүснэгт 1-1-т, техникийн мэргэжилтнүүдийг Хүснэгт 1-2-т тус тус тусгасан болно.

Хүснэгт 1-1 БОНИНУ-ний баг

Нэр	Үүрэг	Компани
Rachael Bailey	Төслийн захирал / Байгаль орчны мэргэжилтэн	Аркадис
Katie Prebble	Төслийн менежер / БОНИНУ мэргэжилтэн	Аркадис
Adam Khan	Төслийн зохицуулагч	Аркадис
Dr Magnus Macfarlane	Олон улсын нийгэм, жендерийн мэргэжилтэн	Оушн Ревайв
Amir Shah	Эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтэн	Аркадис
Sarah Winne	Уур амьсгалын мэргэжилтэн	Аркадис
Энхтулга Төмөрбаатар	Багийн ахлагч	Экотрэнд
Цэрэнханд Гүрбадам	Нийгэм, жендерийн мэргэжилтэн	Экотрэнд
Түвшинтөгс Сүхбаатар	Шувуу судлаач	Экотрэнд

Хүснэгт 1-2 Техникийн мэргэжилтэн

Нэр	Үүрэг	Компани
Martina Girvan	Биологийн олон янз байдал, экосистем, байгалийн капитал болон байгальд суурилсан шийдлийн мэргэжилтэн	Аркадис
Richard Anderton	Экологи, шувуу судлал	Аркадис
Lisa Driscoll	Гидрологи, усны голдирол	Аркадис
Thomas Wright	Агаарын чанар	Аркадис
Mark Arnold	Дуу шуугиан, доргион чичиргээн	Аркадис
Jenny Wylie	Соёлын өв	Аркадис
Charles Hutchinson	Тээвэр	Аркадис
Bruce Lascelles	Хөрс	Аркадис
Ben Hilder	Байгаль орчны дүр төрх, үзэгдэх байдлын нөлөөлөл	Аркадис
Хүрэлсүх Дулмаа	Биологи / шувуу судлал	Экотрэнд
Сүмжидмаа Төмөрчөдөр	Нийгмийн мэргэжилтэн	Экотрэнд
Номин-Эрдэнэ Батцож	Экологи	Экотрэнд
Баярсайхан Пүрэвжав	Байгаль орчны мэргэжилтэн	Экотрэнд
Үүрийнцолмон Энхтайван	Ургамал судлаач	Экотрэнд
Мөнхцэцэг Зоригт	Гидрологи	Экотрэнд
Билгүүн Баярсайхан	Агаарын чанар, дуу шуугиан, доргион чичиргээн	Экотрэнд
Анхбаяр Очирбат	Хөрс, GIS	Экотрэнд
Энхцэцэг Бямбаа	Нүүлгэн суурьшуулалт	Экотрэнд

1.8 Тайлангийн бүтэц

1.8.1 Энэхүү БОНиНУ нь байгаль орчин, нийгмийн дараах сэдвүүдийн үнэлгээний үр дүнг танилцуулж, боломжит их нөлөөлөл болон холбогдох бууруулах арга хэмжээг тусгав. Бүлэг, хавсралтын хураангуйг **Хүснэгт 1-3**-д харуулав.

Хүснэгт 1-3 БОНиНУ тайлангийн бүтэц

Бүлэг	Тайлбар
1: Танилцуулга	Төслийн танилцуулга
2: Төслийн тодорхойлолт	Төслийн тойм, суурь мэдээлэл, барилгын үйл ажиллагаа, хөтөлбөрийн дэлгэрэнгүйг танилцуулна.
3: Хувилбаруудын үнэлгээ	Төлөвлөсөн загварт авч үзсэн өөр байршил болон технологийн талаарх мэдээлэл тусгасан.

Бүлэг	Тайлбар
4: Хууль, стандарт, бодлогын орчин	Төслийн холбогдох улсын болон олон улсын байгаль орчны хууль тогтоомжийг дэлгэрэнгүй тайлбарлана. Мөн ЕСБХБ-ны бодлого, шаардлагыг тусгана.
5: БОНиНҮ-ний аргачлал	Байгаль орчны үнэлгээ хийхэд ашигласан БОНиНҮ-ний аргачлалыг дэлгэрэнгүй тайлбарласан.
6: Талуудын оролцоог хангах	Талуудын оролцооны арга барил, өнөөг хүртэл авсан санал, хариу үйлдлийн хураангуйг танилцуулна.
7: Агаарын чанар 8: Дуу чимээ ба чичиргээ 9: Биологийн олон янз байдал, ургамал, амьтан 10: Соёлын өв 11: Байгаль орчны дүр төрх, харагдах байдал 12: Хөрс, байгалийн аюулт үзэгдэл 13: Усны орчин 14: Нийгэм ба олон нийт 15: Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, амьжиргаа 16: Газрын ашиглалт, эзэмшил ба шилжилт 17: Хөдөлмөр ба ажлын нөхцөл 18: Уур амьсгал 19: Нийлмэл үр дагавар	Байгаль орчин, нийгмийн сэдвүүдийн техникийн нөлөөллийн үнэлгээ.
20: Хураангуй	Болзошгүй бүх нөлөөллийн хураангуй.


2 Төслийн тодорхойлолт

2.1 Танилцуулга

- 2.1.1 Энэхүү бүлэг нь төслийг тодорхойлолт өгч, зураг төсөл, барилгажилт, болон ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ)-ний үе шатыг хамруулна. Мөн энэ тайланд тусгагдсан үнэлгээнд ашигласан гол үндэслэлүүдийг тодорхойлсон болно..
- 2.1.2 Төслийн тодорхойлолт нь голчлон монгол хэлээр ирүүлсэн баримт бичгийн тоймд үндэслэсэн бөгөөд дараах зүйлс хамаарна:
- Зураг төслийн мэдээлэл:
 - Нэгдсэн эрчим хүчний системийн газрын зураг, 2021
 - Эргэлтийн цэгийн координат
 - Сүлжээний судалгаа/Ашиглах горимын шинжилгээний хураангуйтай холбогдох албан бичиг, 2021 оны 4 дүгээр сарын 4
 - 220 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл
 - 220 кВ хоёр хэлхээт агаарын шугамын техникийн нөхцөл: Цагаан суварга – Сайншанд, 2021 оны 4 дүгээр сарын 13
 - Цахилгаан дамжуулах агаарын шугамын трасс сонголтын хураангуй тайлан
 - Дорноговь аймаг – Цагаан суварга 220/22кВ дэд станц өргөтгөл, Цагаан суварга – Сайншандын 220 кВ хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөв, 2022 оны 1 дүгээр сарын 28
 - Цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл болон Цагаан суварга дэд станцын өргөтгөл
- 2.1.3 ЭХЯ, ТХН, ЦДҮС-тэй уулзалт зохион байгуулсан. ТХН, ЭХЯ-ны мэдээлснээр төслийн техник-эдийн засгийн үндэслэл бэлтгэгдээгүй, КОВИД-19 цар тахалын үеэр төсөл эхэлсэн тул шууд нарийвчилсан зураг төслийн шатанд шилжүүлэх шийдвэр гаргажээ.
- 2.1.4 Төслийн холбогдох 2024 оны хавар, намрын шувууны судалгааны тайлан нэмж судалсан болно. Үүнд:
- 2022 оны хаврын шувуун судалгаа (Састэйнабилити Ийст Эйжия болон Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв)
 - 2024 оны намрын шувуун судалгаа (Аркадис)
 - Монгол улс: Сайншанд-Цагаан суварга агаарын шугамын төсөл – төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн үнэлгээ; Эхний тайлан (INTEGRATION Umwelt & Energie GmbH, October 2025)
- 2.1.5 Төслийн барилгын ажлыг хэрэгжүүлэхээр ЭХЯ-аас томилсон барилгын гүйцэтгэгч компани, тулууруудын микро байршлыг тодорхойлох ажил хийгдэхээр төлөвлөж (зөвлөмж болгосон) байна.

2.2 Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал

- 2.2.1 Монгол Улсын эрчим хүчний систем нь нийт 3.5 сая орчим хүн амыг хангадаг бөгөөд системийн хэрэглээний ихэнх нь Төвийн бүсэд төвлөрсөн байдаг. Эрчим хүчний систем нь дөрвөн бүсийн цахилгаан түгээх сүлжээнээс бүрддэг (**Зураг 2-1**-ийг үзнэ үү). Үүнд: Төвийн эрчим хүчний систем (ТЭХС), Баруун бүсийн систем, Зүүн бүсийн систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем орно. ТЭХС нь Монгол Улсын хамгийн том эрчим хүчний сүлжээ бөгөөд нийслэл Улаанбаатар хотын үндсэн хэрэглээг хангаж, улсын нийт цахилгаан үйлдвэрлэл, борлуулалтын 88.8%-ийг бүрдүүлдэг. Тус төсөл нь ТЭХС-д байрлаж байна. ТЭХС-ээс бусад гурван бүсийн сүлжээнүүдийн үйл ажиллагааны хүчин чадал болон цахилгаан хангамжийн чанар нь маш сул хэвээр байна.



Зураг 2-1 Монгол Улсын цахилгаан түгээх сүлжээ ба дамжуулах системүүд (ТЭХС шар өнгөөр тэмдэглэсэн)

- 2.2.2 Сүүлийн арван жилийн эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор Монгол Улсад цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн. Одоогийн байдлаар улсын цахилгаан эрчим хүчний хэрэгцээний 75.4%-ийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдсэн 24.6%-ийг ОХУ болон БНХАУ-аас¹ импортлон хангаж байна. 2024 онд Монгол Улс 8,754.7 сая кВт.цаг цахилгаан үйлдвэрлэж, 2,863.4 сая кВт.цаг (24.6%-ийг импортлосон²).
- 2.2.3 2024 онд дотоодын цахилгаан үйлдвэрлэлийн 90.6% нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудаас, 9.4% нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс бүрдсэн. Сэргээгдэх эх үүсвэрүүдийн дотор, усан цахилгаан станц (нийт сэргээгдэх эрчим хүчний 9%), нарны цахилгаан станц (нийт сэргээгдэх эрчим хүчний 28.2%), салхин цахилгаан станц (нийт сэргээгдэх эрчим хүчний 62.8%) байсан нь 2023 оны дэлхийн дундаж болох 30%-аас доогуур үзүүлэлт юм. 2023 оны байдлаар Монгол Улсад салхин станц 3, нарны станц 9, хэд хэдэн жижиг усан цахилгаан станц ажиллаж байна. 2024 оны байдлаар нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудын


¹ Statistics on Energy Performance 2024. Available at: erc.gov.mn

² ERC, Energy Sector Statistics for 2024. Available at <https://erc.gov.mn/mn/>.

суурилагдсан хүчин чадал 1,319 мегаватт (МВт) байсан бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд (салхи, нар, ус) нь 336.8 МВт-ыг эзэлж байна.

2.2.4 2024 онд Төвийн эрчим хүчний систем (ТЭХС)-ийн цахилгаан үйлдвэрлэлийн нийт суурилагдсан хүчин чадал 826 МВт, нийт цахилгаан эрэлт 729 МВт (улсын нийт ачааллын 95% орчим) байна. ТЭХС-ийн эрчим хүчний эрэлт жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 2030 он гэхэд 2016 оны суурь түвшнээс 78%-иар өсөх төлөвтэй байна. Энэ өсөлт нь бүс нутгийн эдийн засгийн хөгжил болон хотжилт нэмэгдсэнтэй холбоотой.

2.2.5 **Зураг 2-2**-т ТЭХС-ийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүдийг харуулсан. Ихэнх цахилгаан хангамжийг Улаанбаатар хот дахь дулааны цахилгаан станц (ДЦС)#3 болон ДЦС#4-өөс нийлүүлдэг. Монгол Улсын "Алсын хараа 2050" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-той уялдуулан Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц (90 МВт), Цэнэг хуримтлуулах байгууламж (200 МВт) болон Эгийн голын усан цахилгаан станц (315 МВт) төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Азийн Хөгжлийн Банктай (АХБ) хамтран хэрэгжүүлж буй "Сэргээгдэх эрчим хүчний салбарыг өргөтгөх төсөл"-ийн хүрээнд Мөрөнгийн 10 МВт нарны цахилгаан станц 2024 оны 9-р сард ТЭХС-д холбогдсон. Улаанбаатар хотын Баганүүр дүүрэгт баригдсан 50 МВт-ын цэнэг хуримтлуулах байгууламж 2024 оны 12-р сард ТЭХС-д эрчим хүч нийлүүлж эхэлсэн. Мөн 17.5 МВт-ын нарны цахилгаан станц ашиглалтад орох төлөвтэй байгаа ч одоогоор дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. ЭХЯ-ны мэдээлснээр ДЦС 1,378 МВт, салхин станц 155 МВт, нарны станц 130 МВт, цэнэг хуримтлуулах байгууламж 150 МВт хүчин чадалтай байна.



Зураг 2-2 ТЭХС-ийн өдөр тутмын цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт ба эрэлт³

Тайлбар: СНР – Дулааны цахилгаан станц MWe –мегаватт цахилгаан (1 сая ваттын цахилгаан хүчин чадал)
РР – цахилгаан станц PV – нарны цахилгаан станц Тэмдэглэл: 1. Энэхүү зурагт үзүүлсэн мэдээлэл нь 2022 оны симуляцийн үр дүнд үндэслэсэн. 2. Хэвтээ тэнхлэг дээрх утгууд нь онолын нэг өдрийн цагуудыг илэрхийлж, тухайн цагуудад эрчим хүчний нийлүүлэлт ба эрэлтийг тооцоолсон болно.

2.2.6 2024 оны 6-р сард болсон УИХ-ын сонгуулийн дараа зохион байгуулагдсан Монголын Эдийн Засгийн Форум-2024-т Ерөнхий сайд Лувсаннамсрай Оюун-Эрдэнэ эрчим хүчний салбарыг либералчлах зорилгыг зарласан. Үүний хүрээнд Засгийн газар 2024 онд Хөрөнгө оруулалт, худалдаа, монополийн эсрэг бодлого, төрийн худалдан авалтад хариуцсан Шадар сайдаар ахлуулсан Эрчим хүчний шинэчлэлийн үндэсний хороо байгуулсан. Гэвч 2025 оны 7-р сард Засгийн газрын шийдвэрээр тус хороог татан буулгаж, эрчим хүчний салбарын шийдвэр гаргах бүтэц, зохион байгуулалтыг цомхон болгох зорилт тавьсан. Шинэчлэлийн хөтөлбөрт эрчим хүчний зах зээлийг либералчлах, тарифын тогтолцоог шинэчлэх, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг дахин бүтэцжүүлж, хувийн хөрөнгө оруулалтыг татах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилтууд багтсан⁴. Мөн ажлын хэсэг Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэх тухай тогтоомжуудыг шинэчлэх үүрэг хүлээсэн. Эдгээр бодлогын өөрчлөлтүүд нь Монгол Улсын “Алсын хараа 2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдаж, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих, цахилгаан сүлжээний найдвартай байдлыг сайжруулахад чиглэж байна.

2.2.7 Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийг “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлсон. Тухайлбал, 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 30%-д хүргэх, 2030 он хүртэл эрчим хүч үйлдвэрлэл, нийлүүлэлтийн салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг 8.34 сая тонн хүртэл бууруулах зорилтууд багтсан бөгөөд энэ нь бага нүүрстөрөгч бүхий, ногоон эдийн засагт шилжих Монгол Улсын тууштай зорилгыг илэрхийлж байна. Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөц нь 2,600 гигаватт (ГВт)-аар тооцогдож байгаа бөгөөд үүнд салхи, нарны эрчим хүч багтана. Энэ нь Монголын цахилгаан эрчим хүчний одоогийн 1.6 ГВт суурилагдсан хүчин чадлаас 1000 дахин их юм.

2.3 Төвийн Эрчим Хүчний Систем (ТЭХС)-ийн Дамжуулах ба Түгээх Сүлжээ


2.3.1 2024 оны байдлаар Монгол Улсад 220 кВ-ын дамжуулах шугам 2,038 км, 110 кВ-ын дамжуулах шугам 5,764 км, 35 кВ-ын түгээх шугам 10,678 км байгаа бөгөөд эдгээр нь улсын хэмжээнд эрчим хүч дамжуулах, түгээх үндсэн дэд бүтцийг бүрдүүлдэг⁵. **Зураг 2-3**-т ТЭХС-ийн одоо байгаа болон төлөвлөж буй 220 кВ-ын сүлжээ-г харуулсан болно. 2024 оны байдлаар ТЭХС-д 220 кВ-ын дэд станц 11 ширхэг, 110 кВ-ын дэд станц 78 ширхэг, 35 кВ-ын дэд станц 306 ширхэг ажиллаж

³ Source: Asian Development Bank. 2020. Mongolia: Energy Storage Option for Accelerating Renewable Energy Penetration. Consultant's report. Manila (TA 9569-MON). Designing a Grid-connected Battery Energy Storage System - Case Study of Mongolia, April 2023.

⁴ Холбоо: <https://www.esight.mn/post/2945>

⁵ Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо | Energy Regulatory Commission | STATISTICS ON ENERGY PERFORMANCE 2023

байна. Эдгээр дамжуулах шугам, дэд станцуудыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (ЦДҮС) ТӨХК хариуцан ажиллуулж, удирддаг.



Зураг 2-3 ТЭХС-ийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугамууд⁶

2.3.2 ТХН-ийн мэдээлснээр, Төвийн Эрчим Хүчний Систем (ТЭХС)-д дараах 220 кВ-ын дамжуулах шугамуудыг ашиглаж байгаа. Үүнд:

- Сэлэнгэ–Дархан: Хоёр хэлхээтэй, 111.2 км, ОХУ-ын сүлжээтэй холбогддог
- Дархан–Эрдэнэтийн шугам (201, 202), хоёр хэлхээтэй, 153 км
- Улаанбаатар–Эрдэнэтийн шугам (203, 204): Хоёр хэлхээтэй, 257.7 км, ДЦС-4-өөс Эрдэнэтийн дэд станцтай холбогддог
- Хоёр хэлхээтэй (205, 206) шугам 29.5 км шугам, ИНВ 4–Улаанбаатар дэд станцуудтай холбогддог.
- Бaganуур–Чойрын шугам (207), нэг хэлхээтэй, 178 км
- Улаанбаатар–Дарханы шугам (208), нэг хэлхээтэй, 197.7 км, ДЦС-4-өөс Дарханы дэд станцтай холбогддог.
- Улаанбаатар–Bagануурын шугамууд (209, 210), хоёр хэлхээтэй, 117.17 км, ДЦС-4-өөс Bagануурын дэд станцтай холбогддог.


⁶ Available at: <https://transco.mn/reports/report2024/index.html>

- Хоёр хэлхээтэй шугамууд (211, 212), 16.5 км, ИНВ 4–Сонгино дэд станцтай холбогддог.
- Сонгино–Мандалговийн шугамууд (213, 214), 220 кВ-ын шугам, 330 кВ-ын зориулалттай, 249.1 км
- Мандалговь–Тавантолгойн шугамууд (215, 216), хоёр хэлхээтэй, 249.8 км
- Тавантолгой–Оюу Толгойн шугамууд (217, 218), хоёр хэлхээтэй, 136.29 км
- Хоёр хэлхээтэй шугам (219, 220), 12.1 км, Оюу Толгой–Төв дэд станцтай холбогддог.
- Хоёр хэлхээтэй шугам (221, 222): 159.4 км, Оюу Толгой–Цагаан суварга дэд станцтай холбогддог.
- Нэг хэлхээт шугам (225): 184.8 км, Чойр–Мандал дэд станцтай холбогддог.
- Хоёр хэлхээт шугам (261, 262), 71.2 км, Бөөрөлжүүт ДЦС-ыг Багануур дэд станцыг холбодог.
- Оюу Толгой–Хятад, хоёр хэлхээтэй, 175 км

2.3.3 Төлөвлөж буй болон баригдаж буй шугамууд:

- Чойр–Сайншандын хоёр хэлхээтэй шугам, 220 км

2.3.4 Дамжуулах шугамуудыг **Зураг 2-4**-т графикаар үзүүлэв.



Зураг 2-4 ТЭХС-ийн дамжуулах шугамууд

Эх сурвалж: INTEGRATION Umwelt & Energie GmbH Inception Report (2025-10 cap)

2.3.5 Цахилгаан түгээх сүлжээний талаар, Монгол Улсад цахилгаан түгээх үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн компаниуд хариуцан гүйцэтгэдэг. Тус төсөл нь Багануур–Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (БЗӨБЦТС)-д хамаарна. ЦДҮС ТӨХК нь БЗӨБЦТС-д цахилгаан эрчим хүч нийлүүлдэг. БЗӨБЦТС нь 1984 онд байгуулагдсан бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Цахилгаан түгээлт болон зохицуулалттай эрчим хүчний хангамж
- 0.4–110 кВ-ын агаарын шугам, дэд станцын угсралт, засвар, ашиглалт
- Цахилгаан хэмжүүрийн багаж хэрэгслийн угсралт, засвар, худалдаа
- Цахилгаан эрчим хүч болон холбогдох үйлчилгээний импорт.

2.3.6 БЗӨБЦТС нь нийслэлийн нэг дүүрэг болон 7 аймгийн нийт 58 сум, суурин газарт цахилгаан түгээдэг. Нийт дараах 49,637 хэрэглэгчдийг цахилгаанаар хангадаг. Үүнд:

- 5,350 аж ахуйн нэгж, байгууллага
- 44,287 өрх (үүнээс 16,153 нь орон сууцанд, 28,134 нь гэр хороололд⁷ амьдардаг)

- Төслийн үндэслэл

2.4 Төслийн үндэслэл

2.4.1 Монгол Улсын одоогийн цахилгаан дамжуулах дэд бүтэц нь хуучирсан, үр ашиг багатай, найдвартай бус байдалтай бөгөөд дамжуулах шугамын дагуу эрчим хүчний ихээхэн алдагдал гардаг. Монголын эрчим хүчний салбарт тулгарч буй гол сорилтууд нь:

- Цахилгаан үйлдвэрлэх дотоод хүчин чадал хангалтгүй;
- Дамжуулах болон үйлдвэрлэлийн сүлжээг засварлах, өргөтгөхөд шаардлагатай хөрөнгө оруулалт дутмаг;
- Эрчим хүчний салбар дахь хөрөнгө оруулалтын тодорхойгүй байдал;
- Эрчим хүчний хангамжийн хуучирсан дэд бүтцийн үр ашиг багассан
- Шинэ эх үүсвэрээс нэмэлт эрчим хүч хүлээн авах хүчин чадал хязгаарлагдмал, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний хувьсах (VRE) эх үүсвэрүүд болох нарны фото цахилгаан болон салхин цахилгаан станцууд
- Цахилгаан дамжуулах сүлжээний алдагдал өндөр⁸

⁷ Монгол гэр нь дугуй хэлбэртэй, бөмбөгөр оройтой, майхан төстэй сууц бөгөөд хялбархан угсарч, задлах боломжтой, зөөврийн бүтэцтэй юм. Гэр нь байршлын хувьд түр зуурын шинжтэй байж болох ч малчин өрхийн цорын ганц орон гэрийг төлөөлөх нь элбэг. Түүний бүтэц нь хана, унь, тооно зэргээс бүрдэх ба эдгээрийг адууны дэлээр хийсэн уяагаар холбон бэхэлдэг. Дараа нь гэрийг малын ноосоор хийсэн эсгий давхаргаар бүрж, байгалийн хүчин зүйлээс хамгаалахын тулд нэмэлтээр брезентээр хүчих нь түгээмэл.

⁸ Ministry of Energy 2018. Energy Sector of Mongolia, Country Report.

- 2.4.2 Эрчим хүчний салбарын хөгжлийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа 2050"-д тодорхойлсон. 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого" нь "Алсын хараа 2050"-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудыг хөгжүүлэх замаар эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг сайжруулахад чиглэсэн бодлогын хэсгийг агуулдаг. Тус төсөл нь Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан бөгөөд "Алсын хараа 2050"-ийг дэмжих зорилготой.
- 2.4.3 2024 онд ТЭХС-ийн дамжуулах болон түгээх сүлжээний алдагдал нь нийт цахилгаан эрчим хүчний 11.67%-ийг эзэлж байсан. Тус төсөл нь Говийн бүсийн хөгжлийн төслүүдийг цахилгаанаар найдвартай хангах зорилготой. Төслийн хүрээнд Улаанбаатар–Багануур–Чойр болон Чойр–Сайншанд чиглэлийн өндөр хүчдэлийн шугамууд (одоогоор барилгын өмнөх шатанд) болон Улаанбаатар–Мандалговь–Тавантолгой–Оюу Толгой–Цагаан суварга чиглэлийн коридорыг холбосон тойрог хэлбэрийн дамжуулах сүлжээ бий болгож, Говийн бүсийн гол төслүүдэд цахилгаан хангамжийн найдвартай байдал, тогтвортой байдлыг мэдэгдэхүйц сайжруулна.
- 2.4.4 Шинээр баригдсан Бөөрөлжүт, Баян, Багануур, Таван толгой дэд станцууд, мөн хэрэгжиж буй Чойр–Сайншандын 220 кВ-ын дэд станцын төсөл болон Сайншанд–Цагаан суварга төсөл нь цахилгаан дамжуулах сүлжээний хүчин чадлын хомсдлыг арилгаж, найдвартай ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулна. Эдгээр байгууламжууд нь шинээр байгуулагдсан болон баригдаж буй боловсруулах үйлдвэрүүд (жишээлбэл, газрын тосны үйлдвэр, Сайншандын аж үйлдвэрийн парк, зэс боловсруулах үйлдвэрүүд), түүнчлэн төмөр зам, авто замын дэд бүтэц, холбогдох ачилт, буулгалтын байгууламжуудыг Говийн бүс нутагт цахилгаан эрчим хүчээр хангах юм. Тус төсөл нь Сайншанд ба Цагаан суварга дэд станцуудын хоорондын чухал холболт болно.
- 2.4.5 ЭХЯ-ны мэдээлснээр, тус төсөл нь ТЭХС-ийн дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлж, дараах шинээр төлөвлөгдсөн эх үүсвэрүүдээс үүссэн цахилгааныг техникийн хувьд нэгтгэх боломжийг бүрдүүлнэ. Үүнд:
- Raid Mongolia ДЦС – 70 МВт /2027 оны 10 сар/
 - Дархан ДЦС – 50 МВт /2028 оны 5 сар/
 - Даланзадгад – 50 МВт /2028 оны 5 сар/
 - Тавантолгой ДЦС – 600 МВт, I үе шат – 300 МВт /2027 оны 10 сар/, II үе шат – 300 МВт /2028 оны 5 сар/
 - Бөөрөлжүүт ДЦС – 600 МВт
 - I үе шат – 300 МВт /2025 оны 10 сар/,
 - II үе шат – 150 МВт /2027 оны 10 сар/
 - III үе шат – 150 МВт /2028 оны 5 сар/
 - Баян ДЦС – 660 МВт
 - I үе шат – 330 МВт /2027 оны 7 сар/
 - II үе шат – 330 МВт /2028 оны 5 сар/
 - ДЦС-2 – 300 МВт
 - I үе шат – 150 МВт /2028 оны 5 сар/
 - II үе шат – 150 МВт /2029 оны 10 сар/

2.4.6 Төслөөс үр шим хүртэх одоогийн болон ирээдүйн хэрэглэгчид (түгээх сүлжээнд холбогдох нөхцөлтэй):

- Одоогийн хэрэглэгчид:
 - Дорноговь аймаг болон сумд, бизнесийн байгууллагууд, уурхайнууд нь одоогоор сүлжээнд холбогдсон бөгөөд дамжуулах сүлжээний найдвартай байдал нэмэгдсэнээр түгээх сүлжээнд цахилгаан хангамж сайжирна. БЗӨБЦТС нь 58 сум, суурин газарт цахилгаан түгээж, нийт 49,637 хэрэглэгчид үйлчилдэг.
- Төлөвлөж буй хөгжүүлэлтүүд:
 - Дээрх 2.4.5 хэсэгт дурдсан цахилгаан хангамжийн төслүүд
 - Цагаан суваргын уурхайн өргөтгөл
 - Алтанширээ сумын нутаг дахь газрын тосны үйлдвэр
 - Алтанширээгийн металлургийн цогцолбор
 - Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжил

2.5 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдал

Талбайн байршил

2.5.1 Төлөвлөж буй ЦДАШ нь Дорноговь аймгийн зүүн хэсэгт орших Сайншанд хотоос баруун хэсэгт орших Цагаан суваргын уурхай хүртэл үргэлжилнэ. Энэхүү шугам нь дараах дөрвөн сумын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрнө.

Хүснэгт 2-1 ЦДАШ-ын маршрут ба дамжин өнгөрөх сумд

Сумын нэр	ЦДАШ	
	Урт, км	Хувь (%)
Сайншанд	79.2	38.7
Улаанбадрах	25.3	12.4
Сайхандулаан	14.1	6.9
Мандах	85.9	42

- 2.5.2 Сайншанд хот нь Дорноговь аймгийн засаг захиргааны төв бөгөөд Улаанбаатар хотоос ойролцоогоор 415 км зүүн өмнө зүгт байрладаг. Тус хот нь Транс-Монголын төмөр замын чухал зангилаа бөгөөд Зүүнбаян чиглэлийн салаа шугам зэрэг хэд хэдэн төмөр замын шугам дайран өнгөрдөг. Зүүнбаян нь Сайншанд сумын баг юм.
- 2.5.3 Цагаан суварга нь Дорноговь аймгийн баруун хэсэгт орших уурхай бөгөөд Сайншанд хотоос баруун урагш ойролцоогоор 180 км зайд байрладаг. Одоогоор эдгээр хоёр байршлыг шууд холбосон асфальтан авто зам байхгүй.
- 2.5.4 Сайншандын дэд станц нь Сайншанд хотоос зүүн хойд зүгт ойролцоогоор 4.4 км-т, Хуурай Базын Хяр хэмээх газар (далайн түвшнээс дээш ~1,010 м өндөрт) байрлах бөгөөд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (ЕСБХБ) санхүүжилттэй Чойр–Сайншанд ЦДАШ төслийн хүрээнд баригдаж байна (Зураг 2-1). Энэхүү орчуулгыг бичиж буй үеийн байдлаар Барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ЭХЯ/ТХН зохион байгуулж байгаа бөгөөд 2028 он гэхэд ашиглалтад орох төлөвтэй байна. Хэдийгээр Сайншандын дэд станц нь энэ төслийн хүрээнд ажиллах шаардлагагүй ч, Сайншанд–Цагаан суваргын ЦДАШ нь Сайншандын дэд станцтай холбогдож байж ажиллах боломжтой. Харин Цагаан суваргад байрлах 220/35/22 кВ-ын дэд станц (Зураг 2-2) нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй уурхайн талбайн дотор байрладаг.



Фото 2-1 Төлөвлөж буй Сайншандын дэд станцын байршлаас Сайншанд хот руу харсан байдал




Фото 2-2 Цагаан суваргын дэд станцын байдал

- 2.5.5 БОНИНУ-ний багийн хийсэн үнэлгээний дагуу төслийн цахилгаан дамжуулах шугамын коридор нь дараах дэд бүтцүүдийг дайран өнгөрөхөөр байна (**Хүснэгт 2-2, Зураг 2-4 болон Зураг 2-3–2-8**):
- 110 кВ-ын шугам – 3 удаа
 - 35 кВ-ын шугам – 5 удаа
 - 10 кВ-ын шугам – 1 удаа
 - Шилэн кабель – 1 удаа
 - Асфальтан авто зам – 2 удаа
 - Сайжруулсан шороон зам – 5 удаа
 - Төмөр зам – 3 удаа

- Хүснэгт

2-2 Төслийн маршрут ба орон нутгийн дэд бүтцийн огтлолцол

	Тулгуурын дугаар	Байршил	E	N	Тулгуурын төрөл	Дэд бүтцийн байгууламж
1	54	ПК156+54.32	287064.7	4877197	У220-2+9	35 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ
2	57	ПК165+64.32	287927.3	4877486	ПС220-2	Шилэн кабель
3	77	ПК224+59.34	293515.5	4879363	ПС220-2	Сайжруулсан шороон зам
4	99	ПК290+69.34	299781.4	4881468	ПС220-2	35 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ
5	125	ПК368+13.76	307122.8	4883934	ПС220-2	Сайжруулсан шороон зам
6	133	ПК392+48.76	309431	4884710	ПС220-2	Сайжруулсан шороон зам
7	134	ПК395+28.76	309696.4	4884799	ПС220-2	Сайжруулсан шороон зам
8	146	ПК431+46.33	313253.9	4885171	ПС220-2	Сайжруулсан шороон зам
9	210	ПК624+96.67	331562.3	4889836	У220-2+9	Төмөр зам
10	212	ПК631+12.31	331807.9	4890277	ПС220-6	35 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ
11	640	ПК1906+58.53	429541.5	4965695	У220-2+9	Төмөр зам
12	645	ПК1920+45.90	430793.1	4966294	У220-2+9	Авто зам
13	651	ПК1937+72.72	432358.4	4967044	ПС220-2	10 кВ-ын ЦДАШ
14	655	ПК1950+17.21	433471.8	4967577	У220-2+9	35 кВ болон 110 кВ-ын ЦДАШ
15	670	ПК1994+86.66	436811.3	436811.3	ПС220-2	110 кВ-ын ЦДАШ
16	673	ПК1999+44.35	437148	437148	У220-2+5	Авто зам
17	673	ПК2001+66.98	437285.3	4970938	ПС220-6	35 кВ-ын ЦДАШ
18	674	ПК2004+04.68	437432	4971125	У220-2+9	110 кВ-ын ЦДАШ
19	678	ПК2015+37.55	437643.1	4972238	У220-2+9	Төмөр зам
20	684	ПК2030+09.14	437407	4973673	ПС220-6	110 кВ-ын ЦДАШ



Зураг 2-5 Тэслийн маршрут ба орон нутгийн дэд бүтэц



Фото 2-3 Баруун өмнөөс зүүн хойд чиглэлд харсан байдал. ЦДАШ-ын трасс Сайншанд–Замын-Үүд чиглэлийн авто зам болон төмөр замыг хөндлөн огтолж буй хэсэг, ойролцоогоор 5 дахь км орчим



Фото 2-4 Зүүнээс баруун чиглэлд харсан байдал. ЦДАШ-ын трасс одоо байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамыг хөндлөн огтолж буй хэсэг, ойролцоогоор 5 дахь км орчимд



Фото 2-5 Хоёр дахь төмөр замтай огтлолцож буй байршлын харагдах байдал



Фото 2-7 Зүүн хойд чиглэлээс баруун өмнө зүг рүү харсан байдал. Ойролцоогоор 59 дэх км-т байрлах эргэлтийн цэгээс харагдах байдал


Фото 2-6 Огтлолцох гурав дахь төмөр замын далангийн харагдах байдал



Фото 2-8 Трассын дагуух одоо байгаа 35 кВ-ын ЦДАШ

Төсөл хэрэгжих орчны байдал

- 2.5.6 Төслийн орчныг **Зураг 2-5** болон **Зураг 2-9–2-14**-т харуулсан болно. Төслийн талбай нь Их Говийн бүсийн Зүүн Говийн хотгорын бүсэд байрладаг. Энэ газар нутаг нь ихэвчлэн 1,000 метрээс доош өндөртэй уудам тал газруудтай бөгөөд 1,000–1,100 метр өргөгдсөн намхан толгодтой.
- 2.5.7 Сайншанд хот нь төлөвлөж буй Сайншандын дэд станцаас ойролцоогоор 4.4 км зайд орших хамгийн ойрын хүн ам суурьшсан төв юм. Сайншанд хотоос бусад хэсгийг эс тооцвол, төлөвлөж буй ЦДАШ нь хөдөө, хүн ам суурьшил багатай бүс нутгаар дайран өнгөрнө. Сайншанд хотоос гадна Зүүнбаян болон Мандах нь төлөвлөж буй трассын чиглэлд хамгийн ойр байрлах, байнгын суурьшилтай хот суурин газрууд бөгөөд ойролцоогоор 44 км-ийн зайтай. Харин Улаанбадрах сумын төв нь Цагаан суварга уурхайтай хамгийн ойр тогтмол суурьшсан суурин газар бөгөөд ойролцоогоор 93 км хойд зүгт байрладаг.



Зураг 2-6 ЦДАШ-ын трасс болон ойролцоох суурин газрууд



Фото 2-9 Сайншанд хотоос одоо ажиллаж буй салхин турбин болон нарны цахилгаан станцын харагдах байдал



Фото 2-11 Өндөрлөг газар алсаас харагдах байдал



Фото 2-13 Төслийн талбайд мал маллаж буй байдал

Фото 2-10 ЦДАШ-ын трассын дагууд харагдах байдал



Фото 2-12 Төслийн талбайд байрлах малчны өвөлжөөний харагдах байдал



Фото 2-14 Төслийн талбайд мал маллаж буй байдал

2.6 Төлөвлөж буй буй төслийн байгууламжууд

Цахилгаан дамжуулах шугам

- 2.6.1 Тус төсөл нь 220 кВ-ын хоёр хэлхээтэй, 204 км урттай өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас бүрдэнэ. Энэхүү шугам нь ямар нэгэн салаалсан холболтгүй байх бөгөөд энэ нь хоёр дэд станцын хооронд цахилгаан дамжуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх давуу талтай. Дамжуулагч утсыг AS-400/51, газардуулгын утсыг JD70-2000 загвараар сонгоно. Мөн А 48 core шилэн кабель болон хэт хүчдэлээс хамгаалах кабель (техникийн үзүүлэлт: ОКГТ-Ц-А-48) нийлүүлнэ. Дамжуулах шугамын тулгуур багана болон шугамуудыг ган болон хөнгөн цагаанаар үйлдвэрлэх бөгөөд эдгээр материалыг олон улсын компаниудаас нийлүүлнэ.
- 2.6.2 ЦДАШ-ын трассын дагуу чиглэл болон газрын өндөршил өөрчлөгдөх тул өөр өөр төрлийн баганууд шаардлагатай. Эрчим хүчний шугамын чиглэл тогтвортой эсвэл өнцөг, өндөршил өөрчлөгдөх эсэхээс хамааран баганын төрөл сонгогдоно. Тус төсөлд нийт 690 ширхэг тулгуур шаардлагатай бөгөөд энэ талаар **хүснэгт 2-3** болон **Зураг 2-7**-д нэгтгэн харуулсан болно. Тулгуурдын өндөр нь 36 метрээс 41.5 метрийн хооронд хэлбэлзэнэ. Төрөл бүрийн тулгууруудын суурийн техникийн үзүүлэлтүүдийг **зураг 2-8**-д үзүүлсэн. Чиглэлийн дагуух газрын гадаргын өндөршил болон геоморфологийн онцлог (хад чулуу, хуурай голын сайр, толгод, хөндий гэх мэт)-оос шалтгаалан тулгууруудын хоорондын зай харилцан адилгүй байна. Анкер тулгуурын хоорондын зай 139–323 метр, шилжилтийн тулгуурын хоорондын зай 139–7,449 метрийн хооронд хэлбэлзэнэ.

Хүснэгт 2-3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурууд

Төрөл (Зураг 2-7-г үзнэ үү)	Суурийн байгууламж (Зураг 2-8-г үзнэ үү)	Тоо хэмжээ	Өндөр
PS220-2/ПС220-2	4хФ3-2, 4хАР-6	612	36 м
PS220-2/ПС220-6	4хФ3-2, 4хАР-6	31	41.5 м
U220-2/У220-2	4хФ5-Ам, 16хАР-6	31	31.6 м
U220-2+5/У220-2+5	4хФ5-Ам, 16хАР-6	7	36.2 м
U220-2+9/У220-2+9	4хФ5-Ам, 16хАР-6	8	40.6 м
U220-2+9/У220-2+9	4хФ3-2, 4хАР-6	1	40.6 м

Хэлхээнэй тоо	Хоёр хэлхээт	Хоёр хэлхээт	Хоёр хэлхээт	Хоёр хэлхээт	Хоёр хэлхээт
Түлүүрийн төрөл	Завсрын түлүүр	Завсрын түлүүр	Эргэлтийн ба таталтын анкер түлүүр	Эргэлтийн ба таталтын анкер түлүүр	Эргэлтийн ба таталтын анкер түлүүр
Мөсжилтийн район	III-IV	I-IV	I-IV	I-IV	I-IV
Дэмжүүлэгчийн хэлбэр	AC-300/39, AC-400/51	AC-300/39, AC-400/51	AC-300/39, AC-400/51	AC-300/39, AC-400/51	AC-300/39, AC-400/51
Троссын хэлбэр	ОКГТ-Ц-А-48 G.6520-14,0	ОКГТ-Ц-А-48 G.6520-14,0	ОКГТ-Ц-А-48 G.6520-14,0	ОКГТ-Ц-А-48 G.6520-14,0	ОКГТ-Ц-А-48 G.6520-14,0
Төрөл					
	Түлүүрийн нөлөө	Түлүүрийн нөлөө	Түлүүрийн нөлөө	Түлүүрийн нөлөө	Түлүүрийн нөлөө
Түлүүрийн жин, кг	Цинкгүй	5503	8467	14398	17603
	Цинктэй	5517	8798	14981	18290
Түлүүрийн жин, кг	Цинкгүй	5503	8467	14398	17603
	Цинктэй	5517	8798	14981	18290

Зураг 2-7 Таталтын тулгуурууд


Foundation Specification Sheet

Foundation type	Ф3	Ф5	AP-6
Model			
Type	Ф3-2	Ф5-Ан	AP-6
Pylon	(P) П220-2	(U) У220-2, У220-2-5, У220-2-9	П220-2, П220-6, У220-2-5, У220-2-9
Page number	(MP) МП-020-21-II-3-11-1	(MP) МП-020-21-II-3-9	(MP) МП-020-21-II-3-13
Height, m	2.7	3.1	3.5
Area of foundation, m	1.8x1.8	2.7x2.7	0.5x0.2
Area of foundation, m	1.8x1.8	2.7x2.7	2.7x2.7
Installation depth, m	2.5	3	-
Volume of steel-reinforced concrete, m³	1.11	2.5	0.275
Weight of steel, kg	133	587	760


Зураг 2-88 Тулгуурын суурийн техникийн үзүүлэлтүүд

2.6.3 Баганын суурийг барих ажил нь ган болон төмөр бетон бүтцийн нуралт, эвдрэлээс сэргийлэх зорилгоор барилгын үндэсний норм ба дүрэм (БНБД 20-03-11 болон БНБД 20-02-11)-ийн дагуу гүйцэтгэнэ. Дээр дурдсанчлан, хоёр төрлийн суурийн системийг ашиглана: '4хФ5-Ам' болон '4хФ3-2'. АР-6 элемент нь хэвтээ чиглэлтэй төмөр бетон бүрэлдэхүүн хэсэг бөгөөд суурийн бүтцэд нэгтгэгдэн нэмэлт бүтцийн бат бөх байдлыг хангах зориулалттай. Эдгээр тулгууруудын суурийн зураглалыг **зураг 2-9**-д үзүүлсэн болно. Тулгуур болон суурийн бетон хөл, мөн кабелийн бетон тавцанг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авч, төслийн талбай руу тээвэрлэнэ. Дунджаар нэг чиргүүлт ачааны машинаар дөрвөөс зургаан ширхэг баганын бетон суурийг ачих, тээвэрлэх боломжтой.

Installation drawing of the Ф5 type foundation




Installation drawing of the Ф3-2 type foundation



Зураг 2-9 Тулгуурын суурийн төлөөлөх загварчилсан угсралтын зураг

Сайншанд дэд станц

- 2.6.4 Чойр-Сайншандын ЦДАШ төслийн хүрээнд баригдах дэд станцын байршлыг **Зураг 2-9**-д харуулав. Энэхүү дэд станц нь Сайншанд-Цагаан суварга төслийн барилгын ажил эхлэхээс өмнө баригдахаар төлөвлөгдсөн.




Зураг 2-10 Сайншанд дэд станцын байршил

Тус төсөлд зориулан Сайншандын дэд станцад шаардлагатай тоног төхөөрөмжүүд дараах байдалтай байна: 220/110/35 кВ-ын 200 МВА хүчин чадалтай автотрансформаторууд:

- 220 кВ-ын хуваарилах төхөөрөмжүүд
- Дотоод хэрэглээнд зориулсан трансформатор
- Тогтмол гүйдлийн (DC) систем
- Кабель шугамууд
- Гэрэлтүүлгийн систем
- Аянга зайлуулагч
- Хяналтын систем
- Реле болон автоматжуулалтын систем
- Аюулгүй байдлын камер
- Байгалийн гамшгаас хамгаалах систем
- Харилцаа холбооны систем

Цагаан Суварга дэд станц

- 2.6.5 Тус төсөл нь Цагаан суваргын одоо байгаа дэд станцтай холбогдох бөгөөд уг дэд станц нь Цагаан суваргын уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд, Монголын Алт Корпораци (МАК)-ийн эзэмшил, үйл ажиллагааны газарт байрладаг (**Зураг 2-11**). Дэд станц нь одоогоор ЦДҮС ТӨХК-ийн өмчлөл, ашиглалтад байгаа боловч МАК-ийн эзэмшлийн газар дээр байрладаг. Монгол Улсын Засгийн газар нь МАК компаниатай хамтран уурхайн хувьцаа эзэмшигч болох талаар хэлэлцээр хийж байгаа бөгөөд энэхүү хэлэлцээрийн хүрээнд дэд станц байрлаж буй газрыг төрийн өмчид шилжүүлэх (өөрөөр хэлбэл ЦДҮС ТӨХК) концессын гэрээ байгуулах төлөвтэй байна. Энэхүү концессийн гэрээ 2026 он гэхэд хүчин төгөлдөр болно гэж урьдчилан тооцож байна.
- 2.6.6 Цагаан суваргын дэд станцаас гарах таван ширхэг цахилгаан сүлжээний холболттой бөгөөд 22 кВ-ын ЦДАШ нь тус дэд станцаас Дорноговь аймгийн Хатанбулаг сумын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч нийлүүлдэг. Төслийн холболтод зориулан дэд станцын доторх тодорхой хэсгийг сонгосон байна.



Зураг 2-11 Цагаан Суварга дэд станцын байршил

2.6.7 Тус төслийн хүрээнд Цагаан суварга дэд станцад шаардлагатай тоног төхөөрөмжүүд дараах байдалтай байна: Трансформатор болон холбогдох тоног төхөөрөмж

- 220 кВ-ын SF₆ хийт таслуур
 - Нэрлэсэн хүчдэл: 252 кВ, давтамж: 50 Гц
 - Нэрлэсэн гүйдэл: 4000 А, богино залгааны гүйдэл: 50 кА
- 220кВ-ын гурван туйлт салгуур, хоёр газардуулагчтай (хуурай төрөл)
 - Нэрлэсэн хүчдэл: 123 кВ, Давтамж: 50 Гц
 - Нэрлэсэн гүйдэл: 2500 А, Богино залгааны гүйдэл: 50 кА
- 220 кВ-ын гурван туйлт салгуур, нэг газардуулагчтай (хуурай төрөл)
 - Нэрлэсэн хүчдэл: 123 кВ, Давтамж: 50 Гц
 - Нэрлэсэн гүйдэл: 2500 А, Богино залгааны гүйдэл: 50 кА
- 220 кВ-ын нэг туйлт салгуур, нэг газардуулгатай (Хуурай төрөл)
 - Нэрлэсэн хүчдэл: 123 кВ, Давтамж: 50 Гц
 - Нэрлэсэн гүйдэл: 2500 А, Богино залгааны гүйдэл: 50 кА
- 220 кВ-ын хэт хүчдэлээс хамгаалах төхөөрөмж
- 220 кВ-ын нэг фазын трансформатор
- Гурван ороомогтой, Нэрлэсэн хүчдэл: 220 кВ, Давтамж: 50 Гц
 - Нарийвчлалын ангилал: 0.5 / хамгаалалт (ЗР)
 - Ачааллын чадал: 30 / 80 ВА
- 220 кВ-ын гүйдлийн трансформатор
 - Нэрлэсэн хүчдэл: 220 кВ, Давтамж: 50 Гц
 - Хоёрдогч ороомгийн нарийвчлалын ангилал: 0.2S / 0.5 / 10P / 10P / 10P
 - Ачааллын чадал: 30 / 30 / 50 / 50 / 50 VA
 - Хувиргалтын харьцаа: 1000 / 5 А
- Хяналт ба автоматжуулалтын систем
 - 220 кВ-ын шугамын реле хамгаалалт ба автоматжуулалтын иж бүрэн самбар
 - Иж бүрэн синхрон хяналтын самбар
 - Иж бүрэн харилцаа холбооны самбар
 - Шилэн кабелийн харилцаа холбооны систем

2.7 Хамгаалалтын зурвас тогтоох тухай

- 2.7.1 Монгол Улсын 2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон хувилбарт зааснаар, шугаман эрчим хүчний дэд бүтцийн хамгаалалтын зурваст байрласан барилга байгууламж, айл өрх, мод бутыг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй байдлын бүсийг хамгаалах арга хэмжээ авах үүргийг аймаг, сумын Засаг дарга хүлээнэ. Хуулийн 33-р зүйл нь сүлжээний аюулгүй байдлын бүсийн хязгаарыг тодорхойлж, тухайн бүсэд гэр, орон сууц, барилга байгуулах болон сүлжээний эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Гэхдээ ямар үйл ажиллагаа зөвшөөрөгдөх эсвэл хориглогдох талаар тодорхой заагаагүй.
- 2.7.2 33-р зүйлд мөн аймаг, сумын Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулах үүрэгтэй. Хэрэв хамгаалалтын бүсэд ургасан эсвэл тарьсан мод, бут нь сүлжээнд саад учруулж, үзлэг, засвар үйлчилгээ хийхэд хүндрэл үүсгэж болзошгүй бол эзэмшигч нь тэдгээрийг тайрах эсвэл шилжүүлэн суулгах үүрэгтэй. Хэрэв эзэмшигч энэ үүргээ биелүүлэхгүй бол эрчим хүчний хяналтын улсын байцаагч эсвэл эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан нь мод бутыг тайрах, шилжүүлэн суулгах арга хэмжээ авах эрхтэй. Түүнчлэн улсын эрчим хүчний байцаагч эсхүл нийлүүлэгчийн эрх бүхий ажилтан нь аюулгүй бүсийн дагуу байрлах бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжаар нэвтрэх, дамжин өнгөрөх эрхтэй. Хэрэв өмчлөгч нь энэхүү хуулийн 33.3-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд улсын эрчим хүчний байцаагч эсхүл нийлүүлэгчийн эрх бүхий ажилтан нь мод, бут сөөгийг шилжүүлэх, тайрах арга хэмжээ авах бөгөөд боломжгүй тохиолдолд тэдгээрийг тайруулах арга хэмжээ авна.
- 2.7.3 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолоор Эрчим хүчний тухай хуулийн 33-р зүйлд үндэслэн эрчим хүчний шугам сүлжээг хамгалах дүрмийг баталсан. Тус тогтоолд Эрчим хүчний сүлжээ эзэмшигч байгууллага нь сүлжээний бүсийн зураглалын хамт гаргасан хүсэлтэд үндэслэн аймаг, сум, дүүргийн Засаг дарга хамгаалалтын зурвасыг тогтоох шийдвэр гаргана гэж заасан. Тогтоолд мөн тусгайлсан аюулгүй байдлын бүсийн хэмжээг дараах **хүснэгт 2-4**-т тодорхойлсон бөгөөд 220 кВ-ын шугамын шаардлагуудыг цэнхэр өнгөөр тэмдэглэсэн.

Хүснэгт 2-4 Монгол Улсын цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвас

Цахилгааны шугам, кВ	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Ой цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
	Баганын гадна талаас (м)		Бүх чиглэлд (м)	Баганын гадна талаас (м)
1 кВ хүртэл		1-1.5 м		
1- 20 кВ	10м	2 м	10 м	2 м
35 кВ	15 м	4 м	15 м	3 м
110 кВ	20 м	5 м	20 м	3 м
220 кВ	25 м	6 м	25 м	4 м

330 -500 кВ	10 м	30 м	30 м	5 м
-------------	------	------	------	-----

- 2.7.4 Сүлжээний эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хамгаалалтын зурваст барилга, орон сууц, хашаа барих болон аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Эрчим хүчний шугамын хэвийн ажиллагаа, дэглэмд саад учруулах аливаа үйлдэл, үйл ажиллагаа хориотой.
- 2.7.5 Дэд станц болон цахилгаан хуваарилах байгууламжийн эргэн тойронд 25 м-ийн радиуст мод, хөдөө аж ахуйн таримал ургамал тарихыг хориглоно. Хамгаалалтын бүсэд ургасан мод, бут нь сүлжээнд саад учруулж болзошгүй бол эзэмшигч нь тэдгээрийг тайрах эсвэл шилжүүлэн суулгах үүрэгтэй.
- 2.7.6 Хамгаалалтын бүсэд ямар үйл ажиллагаа зөвшөөрөгдөх талаар тодорхой заагаагүй боловч сүлжээ эзэмшигч болон орон нутгийн Засаг даргаас зөвшөөрөл авах шаардлагатай гэж ойлгогдож байна.
- 2.7.7 Хэрэв эрчим хүчний сүлжээг бусдын эзэмшил, ашиглалтын газарт байгуулах шаардлагатай бол үүсэх бүх зардлыг сүлжээ барьж буй байгууллага хариуцна.
- 2.7.8 5.1-р зүйлд зааснаар, энэхүү дүрмийн биелэлтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эрчим хүчний зохицуулагч болон хяналтын улсын байцаагч, эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага өөр өөрийн чиглэлээр хяналт тавин ажиллана.
- 2.7.9 Хамгаалалтын зурвас дотор газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан нөхөн сэргээх шаардлагатай.

2.8 Газар чөлөөлж авах, эзэмших эрхийг хязгаарлах

- 2.8.1 ЦДАШ-ын трассыг баталгаажуулахын тулд Эрчим хүчний яамны захиалгаар трассыг тодорхойлсон MasterPoint LLC компани нь дараах байгууллагуудаас баталгаажуулсан гарын үсэг бүхий зөвшөөрлийн хуудас авсан. Үүнд: ЦДҮС ТӨХК, Дорноговь аймаг, Монголын төмөр зам, Онцгой байдлын ерөнхий газар, диспетчерийн үндэсний төв, Багануур–Зүүн өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ, Газар зохион байгуулалт, Геодези зурагзүйн ерөнхий газар, Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК-ийн Дорноговь дахь салбар.
- 2.8.2 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын шаардлагын дагуу (дээр дурдсанчлан), ЦДҮС нь аймаг, сумын холбогдох Засаг дарга нараас газрын албан ёсны шилжүүлгийг төслийн хэрэгцээнд, өөрөөр хэлбэл Эрчим хүчний яамны байнгын өмчлөлд шилжүүлэх тухай захирамжийг авах шаардлагатай. EBRD-ийн шаардлагын дагуу, орон нутгийн малчдын бууц эсвэл эд хөрөнгөд нөлөөлөх аливаа газрын асуудлыг тухайн өрхүүдтэй харилцан зөвшилцөх ёстой бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайланд тусгасан болно.
- 2.8.3 **Зураг 2-12**-т төслийн трассын дагуух газар ашиглалтын байдлыг харуулсан. 2025 оны байдлаар дараах уурхайн тусгай зөвшөөрлүүд хүчин төгөлдөр байна:
- Маршрутын дагуу гурван хайгуулын лиценз огтлолцож байна – Өнгөт (Сайншандын өмнө хэсэгт, Сайншанд болон Сайхандулаан сумдыг дамжин өнгөрөх), Цагаан цавын худгийн орчим (Цагаан

суваргын уурхайн хойд талд, Мандах суманд), мөн Довцог худгийн орчим (Цагаан суваргын хойд талд, Мандах суманд).

- Нэг ашиглалтын лиценз – Цагаан суваргын уурхай болон Түмэн өлзий уул / Цагаан суварга, Цагаан суваргын хойд талд шууд байрлах, МАК компанийн эзэмшилд байдаг.

2.8.4 Ашигт малтмал, газрын тосны газар (2025 оны 7 дугаар сарын 8-нд хийсэн гол мэдээлэгчийн ярилцлагын дагуу) болон Эрчим хүчний тухай хууль, 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын шаардлагын дагуу, хэрэв цахилгаан дамжуулах шугам нь аль хэдийн илрүүлж, үнэлгээ хийсэн ашигт малтмалын ордын бүсээр дайран өнгөрөх тохиолдолд төслийн хэрэгжүүлэгч (энэ тохиолдолд ЭХЯ/ТХН) тухайн ордын эрхийг эзэмшигч компанитай хамтран ажиллаж, ОНТЛ маршрутын хувьд “эсэргүүцэлгүй” гэсэн албан ёсны зөвшөөрлийг авах шаардлагатай. Ярилцлагад тэмдэглэснээр, уул уурхайн компаниудын туршлагаас харахад хоёр төрлийн байр суурь илэрдэг: зарим компаниуд дамжуулах шугамын бүтээн байгуулалтыг эерэгээр харж, үйл ажиллагааг дэмжих орон нутгийн дэд станц байгуулах боломж гэж үзэн “эсэргүүцэлгүй” зөвшөөрөл олгодог бол, бусад нь тэсэлгээ зэрэг үйл ажиллагаанд хүндрэл учруулна гэж үзэн сорилт гэж ханддаг. Одоогийн байдлаар ЭХЯ нь төслийн маршрутад огтлолцож буй хайгуулын лиценз эзэмшигч компаниудтай албан ёсны хэлэлцээрт ороогүй байгаа боловч МАК компанитай (Цагаан суваргын уурхай болон Түмэн өлзий уул/Цагаан суваргын уурхайнууд) харилцан холбоо тогтоосон байна.

2.8.5 Өнгөт хайгуулын лиценз 2027 онд, Цагаан цавын худгийн лиценз 2049 онд, Довцог худгийн лиценз 2027 онд дуусах хугацаатай болохыг ойлгож байна. Хайгуулын лицензийн хил хязгаар өөрчлөгдөх, багасах боломжтой боловч ЭХЯ нь тухайн лиценз эзэмшигчидтэй зөвшилцөж, тохиролцох шаардлагатай хэвээр байна.

2.8.6 Төслийн сумдын Газрын албанаас өгсөн мэдээллийн дагуу хөгжлийн зориулалтаар олгогдсон хэд хэдэн газар тодорхойлогдсон бөгөөд дараах байдлаар байна:

- Аж үйлдвэрийн болон технологийн парк байгуулах зориулалттай газар. Энэ газрын эзэмшигч болох “Эрдэнэс Цагаан суварга” ХХК нь одоогоор уг талбай дээр ямар нэгэн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эхлүүлээгүй байна.
- Худалдаа болон олон нийтийн үйлчилгээний байгууламж, төв, цогцолбор байгуулах зориулалттай газар. Одоогийн байдлаар газрын эзэмшигч Х.Саруулбуян нь ямар нэгэн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулаагүй байна.

2.8.7 Дээр дурдсан зүйлсээс гадна, ОНТЛ маршрутын дагуу аймгийн түвшинд хамгаалалттайгаар тогтоогдсон гурван орон нутгийн хамгаалалттай газар (LPA) болон нэн тэргүүлэх ач холбогдол бүхий хамгаалалтын бүс оршиж байна. Харин “Зоогийн хоолой” нь 2019 онд хамгаалалтын ангиллаас гарсан болно.


- Зоогийн хоолой
- Өөшийн говь
- Газага уулын өргөтгөл
- Нэн тэргүүнд хамгаалалтанд авахыг санал болгсон газар


2.8.8 Эдгээр нь аймгийн түвшний хамгаалалтын ангилалтай тул Дорноговь аймгийн Засаг дарга нь эдгээр бүсээр нэвтрэх зөвшөөрөл олгох эрхтэй (**2.8.1-р хэсэгт** заасны дагуу). Дэлгэрэнгүй мэдээллийг **9-р бүлэг: Биологийн олон янз байдал, ургамал, амьтан болон Соёлын өвийн** бүлэгт тусгасан.


2.8.9 ЦДАШ-ын трасс болон түүний хамгаалалтын зурвасын дагууд орон сууцны барилга байгууламж болон бусад байгууламжууд байхгүй. Гэвч ЦДАШ-ын төв шугамын хоёр талд 25 метрээс 1 км-ийн зайд (нийт 2 км-ийн хамгаалалтын бүсэд) устай худаг, малчин өрхүүд (тэдгээртэй холбоотой гэрүүд) байрлаж байгаа.


Одоо байгаа болон төлөвлөж буй дэд станцын талбай болон 25 м-ийн радиуст барилга байгууламж байхгүй (Цагаан суваргын одоо байгаа дэд станцын байгууламжаас бусад). Дэлгэрэнгүй мэдээллийг **16 дугаар бүлэг: Газрын ашиглалт, өмчлөл болон шилжилт хөдөлгөөн** хэсэгт тусгасан болно.


Зураг 2-12 ЦДАШ-ынэ трассын дагуух газар ашиглалт











2.9 Хамааралтай байгууламжууд

- 2.9.1 ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогод хамааралтай байгууламжууд гэж дараах байдлаар тодорхойлсон байдаг. "Төслийн хүрээнд ЕСБХБ-аас санхүүжүүлээгүй боловч тухайн төслийн амжилттай хэрэгжилт, эсвэл тохиролцсон үр дүнд хүрэхэд ЕСБХБ-ны үзэж байгаагаар чухал ач холбогдолтой байгууламж, үйл ажиллагаа юм. Эдгээр нь дараах шинжтэй шинээр баригдах байгууламж, үйл ажиллагаа байна. (i) Тухайн байгууламж, үйл ажиллагаа байхгүй бол төсөл хэрэгжих боломжгүй. (ii) Төсөл оршин тогтноогүй бол баригдах, өргөтгөгдөх, хэрэгжих, эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөгдөхгүй байсан байгууламж, үйл ажиллагаа."
- 2.9.2 Үйлдвэрт урьдчилан үйлдвэрлэсэн бетон суурийг ашигласнаар карьер нээх шаардлагагүй болно. Цагаан суваргын дэд станц аль хэдийн баригдсан бөгөөд Сайншандын дэд станц нь энэ төслийн барилгын ажил эхлэх үед баригдсан байх төлөвтэй байна. Иймд тулгуур болон дэд станцын суурийн барилгын ажилд элс, дайрга зэрэг материал хязгаарлагдмал хэмжээгээр шаардагдаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд орон нутгийн нийлүүлэгчдээс хангана. Иймд карьер эсвэл түр олборлох талбай байгуулах шаардлага гарах магадлал бага гэж үзэж байна. Гэсэн хэдий ч энэ асуудал болон тэдгээрийн байршлыг Барилгын ажил гүйцэтгэгч тодорхойлох бөгөөд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамгийн бага байлгах зарчимд тулгуурлан, холбогдох зөвшөөрлийн дагуу талбайг сонгох үүрэгтэй.
- 2.9.3 Барилгын ажлын үеэр иргэний барилга угсралт, цамхаг босгох, дамжуулагч болон хамгаалалтын зурвас байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхийн тулд бүх цамхагийн байршилд нэвтрэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Нэвтрэх замыг барилгын ажил гүйцэтгэгч тодорхойлно. Боломжтой тохиолдолд, гүйцэтгэгч нь одоо байгаа хатуу хучилттай замыг ашиглах үүрэгтэй. Хэрэв албан ёсны зам байхгүй бол, барилгын өмнөх шатанд гүйцэтгэгч нь төслийн чиглэл дагуух болон төслийн талбай руу/талбайгаас чиглэсэн замын маршрутыг тодорхойлж, мал, малчид болон бусад газрын ашиглагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс тэмдэглэгээ хийх, мөн нэгээс олон шороон зам ашигласнаас үүдэх байгаль орчны хохирлыг бууруулах шаардлагатай. Ашиглалт ба засвар үйлчилгээний үе шатанд аль болох одоо байгаа замыг ашиглана гэж үзэж байна. Трасст нэвтрэх зөвшөөрлийг авсны дараа тээврийн хэрэгслүүд зөвхөн хамгаалах зурвасын дагуу зорчих ёстой бөгөөд энэ нь ЦДАШ руу/талаас олон зам үүсгэхээс сэргийлэх зорилготой. Боломжтой тохиолдолд одоо байгаа замыг ашиглах нь заавал биелүүлэх шаардлага юм.
- 2.9.4 Барилгын ажлын явцад барилгын ажил гүйцэтгэгч нь барилгын үйл ажиллагааг дэмжих зориулалттай талбайн байгууламжууд буюу талбайн оффисууд, агуулах, ажилчдын байр, зогсоолууд зэргийг байгуулах шаардлагатай. Эдгээр байгууламжийн байршлыг барилгын ажил гүйцэтгэгч тодорхойлох боловч, ТХН-ээс үндсэн кемп болон ажилчдын байрлалыг Сайншандын дэд станцын ойролцоо байрлуулах, харин ЦДАШ-ын дагуу ажлын явцтай уялдуулан жижиг кемпүүдийг түр хугацаагаар ашиглах санал гаргасан байна. Жишиг тооцоогоор, трассын 100 км тутамд нэг туслах кемп байгуулах нь стандарт практик тул нийт хоёр эсвэл гурван кемп байгуулагдах төлөвтэй байна.
- 2.9.5 Бетон зуурмагийн үйлдвэр ашиглахгүй. Үйлдвэрлэсэн бетон суурийг талбайд тээвэрлэн авчирна.

2.10 Төслийн үе шатууд

- 2.10.1 Төслийг хэрэгжүүлэх бүх хариуцлагыг ЭХЯ хүлээх бөгөөд энэ үүргийг хэрэгжүүлэхэд ТХН туслалцаа үзүүлнэ. Төслийн барилгын ажлыг гүйцэтгэх барилгын ажил гүйцэтгэгч байгууллага томилогдох бөгөөд тэдний үйл ажиллагааг ЭХЯ-наас томилогдсон хяналтын инженер хянаж ажиллана.

Барилгын өмнөх үе шат

- 2.10.2 Цаашид нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил хийгдэхгүй гэж ойлгогдож байна. Гэсэн хэдий ч тулгуур тус бүрийн эцсийн байршлыг барилгын ажил гүйцэтгэгч нь газар нутгийн нөхцөл, газрын өндөршил, цамхагуудын хоорондын зай зэрэг хүчин зүйлсийг харгалзан тогтоох шаардлагатай. Иймд барилгын ажил гүйцэтгэгч нь хамгаалалтын зурваст нарийвчилсан байр зүйн болон хөрсний геотехникийн судалгаа хийж, нарийвчилсан байршлын төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх үүрэгтэй.
- 2.10.3 Барилгын ажил эхлэхээс өмнө мэдрэмтгий хүлээн авагч объектуудын видео/зураг бүхий баримтжуулалт хийх урьдчилсан судалгаа зайлшгүй хийгдэх шаардлагатай. Одоогийн судалгааны үр дүнгээс харахад эдгээр хүлээн авагчид нь төлөвлөж буй ДЦАШ-ын шугамаас 1 км-ийн радиуст байрлах худаг, гэр бүхий малчин өрхүүд, мөн барилгын ажил гүйцэтгэгчийн ашиглах бусад ажлын талбайнууд (жишээлбэл, кемпүүдийн эргэн тойронд 25 метрийн хамгаалалтын бүс) байх магадлалтай. Энэхүү суурь мэдээллийг бүрдүүлэх зорилго нь: (i) Энэхүү БОННУ-д тусгасан суурь нөхцөлтэй харьцуулж, өөрчлөлт гарсан эсэхийг баталгаажуулах, нэмэлт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлох; (ii) Барилгын ажлын явцад нэмэлт хохирол учраагүй болохыг нотлох, улмаар барилгын дараах нөхөн сэргээлтийн ажлыг зохистой гүйцэтгэхэд оршино.
- 2.10.4 Тулгуурын байршлыг тогтоох ажлыг зайлшгүй хийгдэх шаардлагатай. Энэ нь тулгууруудыг суурилуулах байршлуудыг тодорхойлох үйл явц юм. Байршлыг тогтоохдоо барилгын өмнөх шатанд хийгдсэн судалгааны үр дүнг үндэслэн, хамгаалалтын зурвас болон ажлын талбайд ямар нэгэн барилга байгууламж байхгүй эсэхийг баталгаажуулна.
- 2.10.5 Барилгын өмнөх шатанд ЭХЯ нь төлөвлөж буй ажилд дотоодын байгаль орчны үнэлгээний зөвшөөрлийг авах шаардлагатай. Энэ нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ) болон Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г боловсруулах, хүргүүлэх үйл явцыг хамарна. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ)-г эхлээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)-аас гаргаж, түүн дээр үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г боловсруулж, хянан баталгаажуулна. Энэхүү үйл явцыг энэ тайлангийн **4.3.9-р хэсэгт** тодорхой тусгагдсан. Энэхүү тайланг бичиж буй үеийн байдлаар БОНЕУ-ний шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэн, БОУАӨЯ-нд хүргүүлсэн байна. 2026 оны эхний улиралд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, түүнээс хойш БОННУ-г ирүүлэхээр төлөвлөж байна. БОУАӨЯ нь БОННУ-д шийдвэр гаргахад ойролцоогоор 1–2 сарын хугацаа шаардагдаж болзошгүй.

- 2.10.6 ЭХЯ нь бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх тайлагналын хариуцагч байх шаардлагатай. Газар олж авах үйл явц нь ЕСБХБ-ны “ГШ 5 – Газар чөлөөлж авах, албадан шилжүүлэн суурьшуулах, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт”-ийн шаардлагыг бүрэн хангах ёстой. Иймд, тухайн үе хүртэлх үйл ажиллагааг тайлагнах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Газар чөлөөлж авах болон нүүлгэн шилжүүлэх хүрээ баримт бичиг” боловсруулсан. Нарийвчилсан зураг төсөл боловсруулах үе шатанд, мөн барилгын ажил гүйцэтгэгчийн шаардлагаар түр хугацаанд газар ашиглах шаардлага гарсан тохиолдолд, албадан эдийн засгийн болон/эсвэл бодит нүүлгэн шилжүүлэлт үүсэх магадлалтай тул Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ) болон/эсвэл Амьжиргаа сэргээх төлөвлөгөө (АСТ) боловсруулах шаардлагатай. Одоогийн байдлаар бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт илрээгүй бөгөөд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд хэрэгжиж байгаа. Гэсэн хэдий ч малчдын өвөлжөө бууцуудаар нүүдэллэдэг онцлогийг харгалзан, барилгын ажлыг газар дээр нь эхлүүлэхээс өмнө, мөн тулгууруудын эцсийн байршлыг харгалзан энэ асуудлыг нэмэлтээр баталгаажуулах шаардлагатай.
- 2.10.7 Барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө нэвтрэх замуудыг байгуулж, тодорхой тэмдэглэгээ хийх шаардлагатай. Энэ нь ургамалд хохирол учруулахаас сэргийлэхийн зэрэгцээ малчид болон малтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг зохицуулах зорилготой.
- 2.10.8 Барилгын ажил гүйцэтгэгчийг ЭХЯ нь тендерийн шалгаруулалтын үндсэн дээр сонгоно. Энэхүү баримт бичгийг багтаасан БОНИНҮ-ний ил тод байдлын багц нь барилгын ажил гүйцэтгэгчийн гэрээний шаардлагын нэг хэсэг болно. Энэхүү зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгайлан боловсруулсан **БОНИМТ**-д тусгасан болно.

Барилгын ажлын үе шат

- 2.10.9 Энэхүү БОНИНҮ болон холбогдох баримт бичгүүд, түүний дотор БОНИМТ нь барилгын ажил гүйцэтгэгчийн гэрээний тендерийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Барилгын ажил гүйцэтгэгч нь төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг удирдах хангалттай хүний нөөцтэй байх үүрэгтэй. Тэдгээр үүргийг биелүүлэх чадавхыг ТХН болон хяналтын инженер хянаж үнэлнэ. Барилгын ажил эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь төслийн шаардлагад нийцсэн (ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлагуудтай нийцтэй) олон нийтийн гомдол барагдуулах механизмыг бүрдүүлсэн байх ёстой. Мөн барилгын явцад үүсч болох хөдөлмөрийн харилцааны гомдлыг зохицуулах хөдөлмөр эрхлэлтийн гомдол барагдуулах механизмыг байгууллагын түвшинд ажиллуулах шаардлагатай.
- 2.10.10 Энэхүү баримт бичгийг бичиж буй үеийн байдлаар, барилгын ажил гүйцэтгэгч ажилчдын байрлах кемпүүдийг ашиглах эсэх, мөн түр хугацааны ажлын талбай, агуулах, тээвэр/нэвтрэх замуудын талаарх мэдээлэл хараахан тодорхой болоогүй байна. ТХН-ээс гол кемп болон ажилчдын байрлалыг Сайншандын дэд станцын ойролцоо байрлуулах, харин ЦДАШ-ын дагуу ажлын явцтай уялдуулан жижиг кемпүүдийг түр хугацаагаар ашиглах санал гаргасан. Жишиг тооцоогоор, трассын 100 км тутамд нэг туслах кемп байгуулах нь стандарт практик тул нийт хоёр эсвэл гурван кемп байгуулагдах төлөвтэй байна.

2.10.11 Одоогийн байдлаар тулгуур болон бусад байгууламжийн нарийн байршил тодорхойгүй байгаа тул барилгын ажил гүйцэтгэгч нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамгийн бага байлгах зарчимд тулгуурлан талбайг сонгох шаардлагатай. Албадан эдийн засгийн болон бодит нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, эсвэл боломжгүй тохиолдолд нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах нь энэхүү БОНИНУ, БОНИУТ болон ГЧНШХХ-д тусгагдсан шаардлагуудтай нийцсэн байх ёстой. Мөн барилгын ажил гүйцэтгэгч нь сонгосон эцсийн байршлуудыг үнэлж, шаардлагатай тохиолдолд нэмэлт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Барилгын ажил гүйцэтгэгч дараах үүргүүдийг хүлээнэ:

- (i) Түр талбайн (жишээлбэл, ажилчдын байрлах кемп, түр агуулахын талбай гэх мэт) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх, уг үнэлгээг ЭХЯ/ТХН, ЕСБХБ-д батлуулах;
- (ii) Барилгын ажил дууссаны дараах газар/талбай хүлээлцэх үйл явцыг зохицуулах нэвтрэх болон гарах журам, протокол хөтлөх;
- (iii) БОНИУТ-д тусгагдсан барилгын өмнөх шатны судалгааг гүйцэтгэх;
- (iv) Барилгын ажлын Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНУТ)-г бүрдүүлэх нарийвчилсан менежментийн төлөвлөгөө боловсруулах.

Барилгын ажлын хөтөлбөр

2.10.12 Төслийн тендер зарлах болон гэрээ байгуулах хөтөлбөр одоогоор тодорхойгүй байна. Барилгын ажлыг 2026 онд эхлүүлж, ойролцоогоор 24 сарын хугацаанд үргэлжлэхээр төлөвлөж байна. Энэхүү барилгын хөтөлбөр нь барилгын өмнөх болон дараах үеийн үйл ажиллагаа, тээвэрлэлт, бэлтгэл ажил, туршилт, ашиглалтанд хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг багтаана. Нарийвчилсан барилгын хөтөлбөрийг томилогдсон барилгын ажил гүйцэтгэгч боловсруулна.

Барилгын гол үйл ажиллагаанууд

2.10.13 Барилгын үе шатанд шаардагдах ажиллах хүч, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээллийг барилгын ажил гүйцэтгэгч томилогдсоны дараа тодорхойлно. Гэвч цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн талбайн угсралт болон бэлтгэл шатанд түгээмэл байдлаар дараах ажлууд хийгддэг:

- Барилгын материалын талбай, үйлчилгээ хангамжийн байгууламжууд, ажилчдын кемпийг барих бөгөөд, шаардлагатай тохиолдолд цахилгаан үүсгүүр суурилуулах;
- Барилгын ажилд шаардлагатай хангамж, материал (тээврийн хэрэгсэл, ачааны машин, барилгын тоног төхөөрөмж)-ыг талбайд татан төвлөрүүлэх;
- Түр тэмдэглэгээ байрлуулах, шаардлагатай тохиолдолд замын чиглэл өөрчлөх;
- Тулгуурын суурийг тэгшлэх, малталт хийх – малталт хийхээс өмнө өнгөн хөрсийг хуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт малталт хийнэ. Шон/тулгуурын суурийн талбайг тэгшлэнэ. Боломжтой бол хуулсан хөрсийг ашиглан талбайг зураг төслийн түвшинд тэгшлэнэ;
- Тулгуур/шонг кранаар босгох;
- Шугам татах – тулгуур/шонг босгосны дараа дамжуулагч болон хамгаалалтын утсыг татаж, газрын түвшинтэй харьцах хамгийн бага зайг хангахуйц хэмжээнд "тэнцвэржүүлнэ". Ихэнх тохиолдолд дамжуулагчийг гар аргаар татна. Хувийн өмчийн дээгүүр дамжин өнгөрөх тохиолдолд агаарын шугамын дамжуулагч утсыг тулгуур хооронд шатан байгууламж ашиглан татах;

- Угсралтын ажил болон хоёр дэд станцад тоног төхөөрөмж суурилуулах;
- Хог хаягдлын менежмент;
- Тоног төхөөрөмжийн туршилт ба анхны ажиллагаа – тулгуур/шонг босгож, шугамыг татсаны дараа шугамын ажиллагааг шалгах туршилт, хэмжилт хийнэ. Шугам болон газрын түвшний хоорондын хамгийн бага зай зэрэг үзүүлэлтүүдийг шалгаж, шугамыг зураг төслийн шаардлагын дагуу тэнцвэржүүлнэ.

2.10.14 Барилгын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжүүд дараах байдалтай байна:

- Трактор 96/130
- Крантай трактор
- Трактор 30-2621
- Цахилгаан лебёдка
- Шаттай машин
- Дамжуулагч татах/татаас хийх төхөөрөмж
- Бульдозер
- 5 тонн даацтай ачааны кран
- 6.3 тонн даацтай ачааны кран
- 16 тонн даацтай ачааны кран
- 10 тонн даацтай ачааны кран
- Автомашин / тээврийн хэрэгсэл
- Ачааны машин
- Гагнуурын аппарат
- Компрессор
- Нураалтын алх /цохилтот дрилл/
- Өрөмдлөгийн машин
- Өндөр бүтээмжтэй экскаватор (0.5 м³ шанагатай)
- Үйлчилгээний тээврийн хэрэгсэл
- 140 морины хүчтэй бульдозер
-

Материалын хэрэглээ

2.10.15 Барилгын үе шатанд байгалийн гаралтай болон нөхөн сэргээгдэхгүй нөөцүүдийг хэрэглэнэ. Баганын суурь болон дэд станцын суурийн барилгад элс, дайрга зэрэг материалыг зохих хэмжээгээр шаардлагатай. Эдгээр материалыг шаардлагатай тохиолдолд орон нутгийн нийлүүлэгчдээс хангана. Хэрэглэгдэх хэмжээ нь орон нутгийн материалын хангамжид сөргөөр нөлөөлөхгүйц хэмжээнд хүрэхгүй гэж тооцоолж байна.

2.10.16 ТХН-ийн мэдээлснээр, баганын бүтцэд ашиглагдах гол материалууд нь ихэвчлэн БНХАУ-аас импортлогддог бөгөөд зарим тусгай эд анги, тоноглолыг дотоодын зах зээлээс худалдан авдаг. Худалдан авалтын нарийвчилсан мэдээлэл нь тендерийн явцад тодорхой болно.

Ухаж гаргасан материал

2.10.17 Барилгын үе шатанд үүсэх материалын ихэнх хэсэг нь хөрсний малтлагаас гарсан хаягдал байх төлөвтэй байна. Хөрсний малтлагаас үүсэх хаягдлын гол эх үүсвэр нь тулгуурын суурийг тавих зорилгоор хийгдэх малтлагын ажил юм. Нэг тулгуурын доорх газрын талбайг 10м x 10м гэж тооцоолсон боловч энэ бүх талбайг бүрэн малтах шаардлагагүй тул суурийн мэдээлэлд үндэслэн нийт боломжит малтлагын хэмжээг **Хүснэгт 2-5**-д тооцоолсон болно. AP-6 төрлийн тоног төхөөрөмж нь газрын гадаргуу дээр суурилагддаг тул тэдгээрээс малтлагын хаягдал гарахгүй гэж үзэж байна.

Хүснэгт 2-5 Баганын суурийн үзүүлэлтэд үндэслэн ухагдах материалын хэмжээ

Суурийн төрөл	Тоо хэмжээ	Хөлний тоо	Гүн, м	Талбай, м	Тооцоолсон ухагдах хэмжээ, м³
Ф3-2	644	4 x 644	2.5	1.8 x 1.8	20,865.6
Ф5-Ам	46	4 x 46	3	2.7 x 2.7	4,024.08
Нийт					24,889.68

2.10.18 Төлөвлөж буй хог хаягдлын менежментэд малтлагаас гарсан хаягдлыг (ачааны машинаар хогийн цэг рүү зөөхөөс гадна) дүүргэлтэд ашиглах, талбай дээр үлдээж тэгшлэх; мөн материалыг дахин боловсруулах (талбай дээр эсвэл гадна), шигшиж ангилаад дахин ашиглах (талбайд эсвэл гадна).

2.10.19 Талбай дотор/гадна дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа нь талбайгаас гарч буй хаягдлын хэмжээг бууруулах ач холбогдолтой. Үүний үр дүнд хаягдал зөөвөрлөх ачааны машинуудын хөдөлгөөнийг багасгаж, орон нутгийн хог хаягдлын менежментийн хязгаарлагдмал хүчин чадалд үзүүлэх ачааллыг бууруулна. Хуулах хөрсийг бүхэлд нь талбайд болон түүний орчимд дахин ашиглана гэж тооцоолж байна. Гэсэн хэдий ч төмөр замын барилгын ажилтай холбоотойгоор төслийн талбайд ажиглагдсанчлан, талбайд үлдээсэн хөрсний овоолго үүсгэхээс зайлсхийх нь зүйтэй.

Хог хаягдлын менежмент

- 2.10.20 Төслийн барилгын үе шатанд хатуу хог хаягдал үүсэх бөгөөд үүнд аюултай болон аюулгүй хог хаягдал багтана. Аюулгүй хог хаягдалд барилгын хаягдал (жишээлбэл, барилгын материалын үлдэгдэл, сав баглаа боодлын хаягдал, мод, металл), ердийн ахуйн хог хаягдалууд болох ариун цэврийн болон хүнсний хаягдал, органик материал хамаарна. Аюултай хог хаягдалд тос, тосолгооны материал, будаг, эмульс, түлш, мөн машин механизмын засвар үйлчилгээний явцад үүсэх бага хэмжээний хаягдал (жишээлбэл, тосонд бохирдсон алчуур, хэрэглэсэн тосны шүүлтүүр, хэрэглэсэн тос, тос, түлш асгарсан үед ашигласан цэвэрлэгээний материал) багтана.
- 2.10.21 Барилгын ажлын явцад, ялангуяа ажилчдын байрлах кэмп ашиглагдсан тохиолдолд тухайн талбайд ажиллаж буй ажилчдаас ахуйн хатуу хог хаягдал (АХХХ) үүснэ. Үүссэн АХХХ-ыг зөвшөөрөлтэй хогийн цэгт хүргэж хаяна.
- 2.10.22 Хог хаягдлыг үүсгэх, хадгалах болон зайлуулах үйл явц нь байгаль орчны доройтол, хогийн цэгийн багтаамж буурах, мөн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд эрсдэл үүсгэх болон хөрс, ус, ургамал, амьтан зэрэг бусад нөлөөлөлд өртөгчдөд сөрөг нөлөөтэй байж болно.
- 2.10.23 Хог хаягдлын хэмжээг тооцоолоход шаардлагатай нарийвчилсан мэдээлэл одоогоор байхгүй байна. Монгол Улсад барилгын хог хаягдлыг ихэвчлэн шууд хаядаг бөгөөд дахин боловсруулах ажиллагаа хийгддэггүй. Гэсэн хэдий ч уг төсөл нь хог хаягдлын дахин ашиглалх түвшинг хамгийн багадаа 60%-д хүргэхийг зорих ёстой. Хэрэв төлөвлөлт, менежментийн зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлбэл хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх, дахин ашиглах, дахин боловсруулах боломжийг нэмэгдүүлж, хогийн цэгт хаягдах нийт материалын хэмжээг бууруулахад дэмжлэг болно.
- 2.10.24 Иймд барилгын үеийн хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах нь хог хаягдлыг зайлуулахын өмнө түүнийг тээвэрлэх, боловсруулах, хадгалах үйл явцад зохих журам, бүртгэл болон хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс хамаарна. Эдгээр арга хэмжээг БОНУТ-д тусгасан бөгөөд барилгын ажлын гүйцэтгэгч тэдгээрийг мөрдөн ажиллана.

Ашиглалт, засвар үйлчилгээний үе шат

Ашиглалтын хугацаа

- 2.10.25 Тулгууруудын ашиглалтын хугацаа ойролцоогоор 60 жил байх нь түгээмэл байдаг. Харин өндөр хүчдэлийн агаарын шугамын дамжуулагч, тусгаарлагч болон холбох хэрэгслүүд нь ихэвчлэн 40 жилийн турш ашиглагддаг. Иймд цахилгаан түгээх сүлжээг хэвийн байлгах, цахилгаан хангамжийг аюулгүй, найдвартай байдлыг хангахын тулд тулгуур болон агаарын шугамыг тодорхой хугацаанд шинэчлэн засварлах шаардлагатай.

Ашиглалт, засвар үйлчилгээний үе шат

2.10.26 Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу, мөн Эрчим хүчний яамнаас тогтоосон үндэсний хууль тогтоомж, практикт нийцүүлэн хийгдэнэ. Төслийн ашиглалтын үе шатанд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд: дэд станцуудын ажиллуулалт, агаарын шугам, цамхаг болон хамгаалалтын зурвасын нөхцөл байдлыг хяналт-шинжилгээ хийх, төлөвлөгөөт болон яаралтай засвар, үйлчилгээ, ургамлын хяналт багтана. Олон нийтэд учирч болзошгүй аюулыг анхааруулах зорилгоор дэд станц болон цамхагуудад олон нийтийн аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна.

2.10.27 ЦДАШ-ын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах урсгал засвар үйлчилгээ хийгдэнэ:

- Явган эргүүл: ЦДАШ болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтмол биечлэн шалгаж, шугамын аюулгүй байдал, хамгаалалт, бүтцийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах;
- Хамгаалалтын эргүүл: Хүн ам суурьшсан бүсэд ойр хэсгүүдийг шалгаж, эвдрэл сүйтгэл, модны мөчир шугамд саад учруулсан байдал, гадны оролдлого, шугамын ерөнхий хамгаалалтын нөхцөл байдлыг үнэлэх. Энэ нь эвдрэл сүйтгэлийн шинж тэмдгийг эрт илрүүлж, шуурхай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлнэ;
- Тулгууруудын хяналт ба засвар: Жил бүр нийт цамхагийн 10%-ийг нарийвчлан шалгах шаардлагатай. Тулгуур, тоноглолын сул боолтыг илрүүлж, чангалах нь элэгдлийг багасгаж, эвдрэлээс өмнө элэгдсэн эд ангиудыг солих заалтыг өгөх боломжтой.

2.10.28 ЦДАШ-д төлөвлөгөөт засвар үйлчилгээний хөтөлбөрийг тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн техникийн шаардлага болон засвар үйлчилгээ хийх зайлшгүй шаардлагад үндэслэн хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөт засварын хүрээнд дараах үйл ажиллагаанууд хийгдэнэ. Үүнд:

- Агаарын шугамын хэсгүүдийн тусгаарлагчийг солих;
- Цамхгийн эд ангиудын зэвийг арилгаж, дахин будалт хийх;
- Хуучин шугамын хэсгүүдэд хэрэглэгдэж буй энгийн боолт, гайкыг хулгайд тэсвэртэй бэхлэгчээр солих;
- Нэвтрэх замын дагууд нөхөн сэргээлт хийх;
- Хувиарлах төхөөрөмж, хамгаалалтын систем болон төлөвлөгөөнд тусгагдсан бусад тоног төхөөрөмжийн үзлэг, засвар үйлчилгээ хийх;

2.10.29 Яаралтай засвар үйлчилгээ нь урьдчилан төлөвлөөгүй үйл явдлыг засахтай холбоотой үйл ажиллагааг илэрхийлнэ. Үүнд жижиг доголдлоос (тусгаарлагчийн гэмтэл зэрэг) эхлээд тулгуурын эвдрэл зэрэг томоохон гэмтэл хүртэлх өргөн хүрээний асуудлууд багтаж болно.

Хог хаягдал

2.10.30 Ашиглалтын үеийн шугамын ашиглалт, засварын нарийн ажлууд одоогоор тодорхойгүй байгаа тул үүсэх хог хаягдлын хэмжээг тооцоолох боломжгүй байна. Гэсэн хэдий ч урьдчилан таамаглаж буй хог хаягдлын төрөл нь аюулгүй/идэвхгүй болон аюултай хог хаягдлыг хамрах магадлалтай. Үүнд:

- Тос, тосолгооны материал
- Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн хаягдал (ЭТТХХ)
- Дэд станцуудад үүсэх ахуйн хатуу хог хаягдал (АХХХ)

2.10.31 Засвар, үйлчилгээний ажлыг гүйцэтгэх явцад ажилчид тухайн талбайд өдөр бүр байрлан, удаан хугацаанд ажиллах шаардлага үүсч болзошгүй бөгөөд энэ нь түр хугацаанд хангамжийн үйлчилгээг шаарддаг. Үүний үр дүнд ашиглалтын үе шатанд засвар үйлчилгээний ажилтнуудаас үүсэх магадлалтай дараа хог хаягдлын төрлүүд байна. Үүнд:

- Органик хог хаягдал
- Цаас
- Хуванцар
- Шил
- Төмөр
- Бусад (аюултай болон энгийн хог хаягдал)
- Мөн ЦДАШ-ын дагуу хяналтгүй ахуйн хог хаягдал үүсч болзошгүй.

2.10.32

2.10.33 Ашиглалт ба засвар үйлчилгээний үед хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

- Ажилтнуудад хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, хог хаягдлын менежментийн сайн туршлагын талаар тогтмол сургалт зохион байгуулах;
- Аюултай хог хаягдлыг (эмнэлгийн хаягдал, зай, цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн хаягдал (ЭТТХ) зэрэг) хадгалах зориулалтын тусгай талбай байгуулах;
- Тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн засварын явцад үүссэн хог хаягдлыг (жишээлбэл, тос, тосолгооны материалаар бохирдсон шүүлтүүрүүд) дахин боловсруулах, мөн химийн бодисын хоосон сав, уутыг дахин ашиглах эсвэл дахин боловсруулах;
- Аюултай хог хаягдлыг хадгалах зориулалтын тусгай талбай байгуулах, мөн ийм төрлийн хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниар зайлуулах.

Хаалт, татан буулгалтын үе шат

2.10.34 Төслийг ирээдүйд хаах, татан буулгахтай холбоотой үйл ажиллагаа нь 30 гаруй жилийн дараа явагдах төлөвтэй тул одоогийн байдлаар бүх шаардлагыг нарийн тодорхойлох боломжгүй байна. Төслийг татан буулгах эцсийн хариуцлага нь ЭХЯ болон ЦДҮС ТӨХК-д ногдоно. Ерөнхийдөө буулгах үеийн менежмент болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг барилгын үеийн шаардлагуудтай адил түвшинд хэрэгжүүлнэ. Төслийг хаах, татан буулгах аливаа үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө тухайн үеийн зураг төслийн нөхцөл байдал болон үүсч болзошгүй асуудлуудыг харгалзан шаардлагын албан ёсны үнэлгээг хийх шаардлагатай. Үүсч болзошгүй асуудлууд болон тэдгээртэй холбоотой менежмент, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг зохицуулах зохих байгууллагаар баталгаажуулсан "татан буулгах төлөвлөгөө"-нд тусгах ёстой. Машин механизм, ган бүтээц болон буулгасан материалуудыг боломжтой тохиолдолд дахин боловсруулж, зөвшөөрөлтэй хог хаягдлын цэгт зайлуулна.

2.11 Төслийн хэрэгжүүлэгч болон хариуцсан байгууллагууд

2.11.1 Төслийн хэрэгжилттэй холбоотой гол байгууллагууд болон эрчим хүчний салбарын холбогдох байгууллагуудын товч мэдээллийг **Хүснэгт 2-6**-д үзүүлэв.

Хүснэгт 2-6 Төслийн хэрэгжүүлэгч болон холбогдох эрчим хүчний байгууллагууд

Байгууллага	Төслийн үүрэг	Тайлагнах байгууллага
ЭХЯ	Зээлийн үндсэн хүлээн авагч; эрчим хүчний бодлого болон холбогдох дэд бүтцийн хөгжлийг хариуцна. Төслийг хэрэгжүүлэх, газар эзэмших, ашиглалт ба засвар үйлчилгээний бүх үйл ажиллагааг хариуцна.	Монгол Улсын Засгийн газар
Төслийн хэрэгжүүлэгч нэгжийн (ТХН) зөвлөх	ЭХЯ-ны дэргэд байгуулагдсан бөгөөд төслийн хэрэгжилтийг дэмжих үүрэгтэй.	ЭХЯ
Орон нутаг (аймаг)-ийн засаг захиргаа	Төслийн хүрээнд газар эзэмших, ашиглахтай холбоотой байнгын болон түр хугацааны бүх үйл ажиллагаанд ЭХЯ-нд дэмжлэг үзүүлнэ. Мөн орон нутгийн иргэдтэй холбоо тогтоож, хамтран ажиллана.	ЭХЯ
Яамдын харьяа орон нутгийн албад	Төслийг батлах, барилгын ажилд холбогдох зөвшөөрөл олгох.	Хамааралтай яамд
ЕСБХБ	Төслийн санхүүжилтийг хариуцна.	ЕСБХБ-ны удирдах зөвлөл
Барилгын ажил гүйцэтгэгч	Тендерийн техникийн шаардлагын дагуу төслийн барилгын ажлыг гүйцэтгэнэ.	ЭХЯ
Хяналтын инженер	ЭХЯ нь барилгын ажлын үе шатанд барилгын ажил гүйцэтгэгчийг сонгох үйл явцад туслалцаа үзүүлэх, мөн талбай дээрх гүйцэтгэлийг хянах зорилгоор хяналтын инженер томилно.	ЭХЯ
ЦДҮС ТӨХК	ЦДАШ-ын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцна.	ЭХЯ
Ашиглалт ба засвар үйлчилгээ гүйцэтгэгчид	Ашиглалт ба засвар үйлчилгээний төрөл бүрийн ажлыг гүйцэтгэнэ.	ЭХЯ
Эрчим хүчний зохицуулах хороо	Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн удирдлага болон нийлүүлэлтийг зохицуулна. Үнэ тариф тогтоох, эрчим хүчний нөөцийн бодлого хэрэгжүүлнэ.	Монгол Улсын Засгийн газар

3 Төсөлд авч үзсэн хувилбар

3.1 Танилцуулга

- 3.1.1 Энэ бүлэг нь төслийн хүрээнд болон түүнд холбогдох үндсэн хувилбаруудыг, тухайлбал шугамын өөр чиглэлүүдийг танилцуулж, төслийн хүрээнд сонгогдсон хувилбаруудыг хэрэгжүүлэх гол үндэслэлүүдийг тайлбарлана.
- 3.1.2 Хувилбаруудыг авч үзэхдээ төслийн зорилго, шаардлагыг хангах өөр өөр арга замуудыг судалсан бөгөөд дараах чиглэлүүдээр хувилбаруудыг тодорхойлсон болно:
- а) **Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны төрөл** – энэ нь санал болгож буй үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт оруулах шаардлагатайг илэрхийлнэ; үүнд “юу ч хийхгүй байх” хувилбар буюу тухайн үйл ажиллагааг огт хэрэгжүүлэхгүй байх сонголт багтана.
 - б) **Төслийн байршил болон төлөвлөлт** – төслийн бүхэл бүтэн саналыг хэрэгжүүлэх өөр байршлууд, эсвэл төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувилбарууд, мөн тодорхой талбай дээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон зайн өөр өөр зохион байгуулалтуудыг хамарна.
 - в) **Үйл ажиллагааны технологи болон ашиглалтын шинж чанар** – үүнийг технологийн эсвэл тоног төхөөрөмжийн хувилбарууд гэж нэрлэдэг; ийм хувилбаруудыг авч үзэх зорилго нь ижил зорилгод өөр арга, үйл явц ашиглан хүрэх боломжийг судлах явдал юм.

3.2 Хувилбаруудыг авч үзэх шаардлага

- 3.2.1 БОНИНУ-ний удирдамжид дараах заалт тусгагдсан байдаг:
- “...төсөл хэрэгжүүлэгчийн судалсан боломжит, зохистой хувилбаруудын тайлбар, эдгээр нь тухайн төсөл болон түүний онцлог шинж чанарт хамааралтай байх ёстой. Мөн сонгосон хувилбарыг сонгох болсон гол шалтгааныг, төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж, тодорхой заасан байх шаардлагатай.”*
- 3.2.2 ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1 (ГШ1)-д БОНИНУ-нд дараах зүйлс багтах ёстой гэж заасан:
- “...техникийн болон санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой хувилбаруудыг судалсан байх [...], үүнд төслийг хэрэгжүүлэхгүй байх хувилбар ч багтана. Мөн санал болгож буй арга хэмжээг сонгох үндэслэлийг баримтжуулсан байх шаардлагатай.”*

3.3 Юу ч хийхгүй байх хувилбар


- 3.3.1 Юу ч хийхгүй байх хувилбарыг уг төслийн нэгэн хувилбар болгон авч үзсэн. Энэ тохиолдолд төслийг хэрэгжүүлэхгүй байх нь ирээдүйд төлөвлөж буй Сайншанд дэд станцыг одоо байгаа Цагаан суварга дэд станцтай холбохгүй байх нөхцөл үүсгэнэ. Үүний үр дүнд цахилгаан дамжуулах сүлжээг тойрог хэлбэрээр байгуулах боломжгүй болж, сүлжээний найдвартай байдал, тогтвортой байдлыг сайжруулах зорилго биелэгдэхгүй болно. Ийм сайжруулсан эрчим хүчний сүлжээ нь Говийн бүс нутагт хэрэгжиж буй олон чухал хөгжлийн төслүүдэд онцгой ач холбогдолтой юм. Төслийг хэрэгжүүлэх нь Монгол Улсын Засгийн газрын эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн сүлжээний хангамж, үр ашгийг сайжруулах зорилгод хувь нэмэр оруулна.
- 3.3.2 Ерөнхийдөө, хэрэв уг төслийг хэрэгжүүлэхгүй бол бүс нутгийн эрчим хүчний холболт болон эдийн засгийн хөгжил саарах хандлагатай байх бөгөөд амьдралын чанарыг сайжруулах, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах боломжууд алдагдах магадлалтай.
- 3.3.3 Нөгөө талаас, "юу ч хийхгүй байх" хувилбарыг сонгосон тохиолдолд төслийн хэрэгжилттэй холбоотой үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс зайлсхийх боломжтой. Гэсэн хэдий ч, ЦДАШ-ын төлөвлөсөн байршлыг харгалзан үзэхэд, мөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр уг төслийн нийгмийн, эдийн засгийн, эрүүл мэнд болон аюулгүй байдлын үр өгөөж нь сөрөг нөлөөллөөс давж гарах төлөвтэй байна.

3.4 Хувилбаруудын байршлууд

- 3.4.1 Энэхүү тайланд өмнө нь дурдсанчлан, Эрчим хүчний яам (ЭХЯ) төслийн хувьд техник-эдийн засгийн үндэслэл хийлгээгүй бөгөөд ажлууд шууд нарийвчилсан зураг төслийн шатанд шилжсэн байна. Маршрут сонголтын үйл явцыг нарийвчилсан зураг төслийн тайланд тусгасан. ТХН-ийн мэдээлснээр, "Мастер Пойнт" ХХК 2021 оны 8 дугаар сарын 15–25-ны хооронд талбайн үзлэг хийжээ. Тайлан болон ЭХЯ, ТХН-тэй хийсэн уялдуулалтын дагуу талбайн судалгааны үр дүнд геодезийн хэмжилтээр эргэлтийн цэгүүдийг тогтоон, хамгийн оновчтой маршрутыг сонгосон байна. Альтернатив хувилбаруудыг авч үзээгүй болно.
- 3.4.2 Маршрут сонгох үеийн гол хүчин зүйлс:
- Бартаат бус газар нутгаар шугамын чиглэлийг төлөвлөх (жишээлбэл, намхан толгод, нээлттэй тал хээр, элсэн манхан, жалга, булаг, нуур);
 - Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай болон хувь хүн, байгууллагын өмчлөлийн газарт халдахгүй байх;
 - Цагаан Суварга дэд станцыг ирээдүйд баригдах Сайншандын дэд станцтай холбосон шулуун тэнхлэг дагуух чиглэлийг аль болох багасгах.

- 3.4.3 ЭХЯ-ны ЦДАШ-ын маршрутын сонголтыг баталгаажуулахын тулд маршрутыг тодорхойлсон зураг төслийн баг болох "МастерПойнт" ХХК нь дараах байгууллагуудын гарын үсэг бүхий зөвшөөрлийн хуудсыг авсан байна. Үүнд: Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ, Дорноговь аймаг, Монголын төмөр зам, Онцгой байдлын ерөнхий газар, Диспетчерийн үндэсний төв, Багануур–Зүүн өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ, Газрын харилцаа, Хот байгуулалтын агентлаг, мөн Дорноговь аймгийн Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нэгж багтсан байна.
- 3.4.4 Орон нутгийн иргэд болон малчидтай хэлэлцүүлэг хийгдээгүй болох нь ойлгогдож байна. Төслийн талбайд хөгжлийн түвшин бага, суурин газруудын дэргэдүүр өнгөрөхгүй тул олон хувилбарын оронд орон нутгийн нөлөөллийг харгалзан үзсэн чиглэл сонгох нь зохистой байж болохыг хүлээн зөвшөөрч байна. БОНИНҮ-ний хүрээнд хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж тэмдэглэгдээгүй боловч ЦДАШ-ын трассаас хоёр тийш 1 км-ийн коридорт 12 өрхийн өвөлжөө, 16 малчин өрхийн зуслан, намаржааны газар байрлаж байна. Иймд шугамын эцсийн чиглэлийг баталгаажуулахаас өмнө эдгээр өрхүүдтэй нэмэлт зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах шаардлагатай.
- 3.4.5 Өмнө дурдсанчлан, Ашигт малтмал, газрын тосны газрын (2025 оны 7 дугаар сарын 8-нд хийсэн ганцаарчилсан ярилцлагын дагуу) мэдээлснээр, төслийн хэрэгжүүлэгч болох Эрчим хүчний яам (ЭХЯ) нь ОНТЛ маршрутын хувьд "эсэргүүцэлгүй" зөвшөөрөл авахын тулд лиценз эзэмшигчидтэй хэлэлцээр хийх шаардлагатай. Одоогийн байдлаар төслийн маршрут дайран өнгөрч буй талбайн лиценз эзэмшигчидтэй ямар нэгэн тохиролцоонд хүрээгүй байна.
- 3.4.6 ЦДАШ-ын трасс нь уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайнуудаас гадна, орон нутгийн тусгай хамгаалалттай гурван газрыг дайран өнгөрдөг.
- Зоогийн хоолой
 - Өөшийн говь
 - Ганзага уулын өргөтгөл
 - Нэн тэргүүнд хамгаалахыг санал болгосон газар

- 3.4.7 Эдгээр нь аймаг болон сумын түвшинд эзэмшигддэг тул маршрутыг өнөөг хүртэл энэ түвшинд баталсан байна. Байгаль орчны нөлөөллийн дэлгэрэнгүй мэдээллийг **9 дүгээр бүлэгт: Биологийн олон янз байдал, ургамал, амьтан** хэсэгт тусгасан болно.
- 3.4.8 Энэхүү Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОНИНУ) хүрээнд маршрутыг үнэлж, дамжуулах шугамын баруун хэсэгт (ойролцоогоор 165–190 км хооронд) орших эмзэг экологийн онцлогийг зайлсхийхийн тулд дахин чиглүүлэх санал гаргасан байна. Одоогийн санал болгож буй маршрут нь төмөр замаас ойролцоогоор 22 км зайтайгаар хазайж байгаа тул маршрутыг төмөр замын дагуу үргэлжлүүлэн явуулж, зөвхөн төмөр замыг огтлох шаардлага гарсан үед чиглэл өөрчлөхийг санал болгож байна. Энэхүү өөр хувилбар нь доорх **3-1 дүгээр зурагт**, 139–210 дугаар тулгуурын хооронд харуулсан бөгөөд нэмэлт эргэлтийн цэгүүдийг бий болгохгүй, харин сайн нөхцөлтэй амьдрах орчныг болон олон тооны шувуудыг (усархаг үед) дэмжих боломжтой түр зуурын нуурын 100 м доторх бүсийг зайлсхийх давуу талтай. Судалгааны үеэр энэ байршилд малчин өрхүүд бүртгэгдээгүй бөгөөд маршрутыг одоо байгаа дэд бүтцэд ойртуулан өөрчлөх саналын нөлөөлөл бага гэж үзэж байна. Гэсэн хэдий ч уг өөрчлөлтийг баталбал газар дээр нь дахин нотлох шаардлагатай.



Зураг 3-1 Санал болгож буй маршрутын шугамын өөрчлөлт

- 3.4.9 Дээр дурдсан зүйлсээс гадна, барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө цамхгуудын нарийвчилсан байршлыг тогтоох шаардлагатай. Энэ нь цамхгуудыг суурилуулах тусгай талбайг тодорхойлох үйл явцыг хэлнэ. Уг үйл ажиллагаа нь барилгын өмнөх судалгаанд үндэслэгдэх бөгөөд хамгаалалтын зурвас болон ажлын талбайд ямар нэгэн байгууламж байхгүйг баталгаажуулна. Хэрэв байгууламж илэрвэл цамхгийн байршлыг өөрчилж, тухайн хөрөнгөд нөлөөлөхөөс зайлсхийх; харин өөрчлөх боломжгүй тохиолдолд нөлөөллийг хамгийн бага түвшинд байхаар байрлуулах шаардлагатай.
- 3.4.10 Эцсийн маршрут дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай:
- Санал болгож буй ОНТЛ маршрутаас 1 км-ийн радиуст орших малчин өрхүүдийн оролцоог хангах
 - Уул уурхайн лиценз эзэмшигчидтэй эцсийн тохиролцоонд хүрэх
 - Эмзэг экологийн бүсүүд – **9 дүгээр бүлэгт: Биологийн олон янз байдал, ургамал, амьтан** хэсгийг үзнэ үү
- 3.4.11 Дэд станцуудын хувьд хамгийн оновчтой сонголт нь одоо ашиглагдаж буй Цагаан суваргын дэд станцын газар болон ирээдүйд байгуулагдах Сайншандын дэд станцын газрыг ашиглах явдал юм. Эдийн засгийн талаас авч үзвэл энэ нь барилгын зардал болон дараагийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлын хувьд хамгийн хямд сонголт бөгөөд нэмэлт газар авах шаардлагыг бууруулж, байгаль орчин болон нийгмийн боломжит нэмэлт нөлөөллийг багасгах давуу талтай.

3.5 Үйл явц болон үйл ажиллагааны онцлог

- 3.5.1 Цахилгаан дамжуулах шугамын хувьд хоёр үндсэн хувилбар байдаг. Өндөр хүчдэлийн агаарын шугам болон газар доорх шугам. Агаарын шугамын гол давуу тал нь газар доорх шугамаас ерөнхийдөө хямд өртөгтэй байдаг (зарим тохиолдолд 2.5 дахин хямд байж болно). Агаарын шугам нь ашиглалтын хугацаа урт, гэмтлийг илрүүлэх, засварлах ажиллагаа хялбар байдаг тул цахилгаан тасалдлын хугацаа богино байдаг. Мөн агаарын шугам нь хэт ачааллыг илүү сайн даах чадвартай. Агаарын цахилгаан шугамыг хэрэглэгчдэд үйлчлэх зорилгоор салгаж, чиглэл өөрчлөх, өөрчлөн тохируулах нь харьцангуй хялбар байдаг. Харин газар доорх шугамд ийм өөрчлөлт хийх нь илүү өндөр зардалтай бөгөөд шугамд хялбархан хүрэх боломжгүй, хэсэгчилсэн шилжүүлэлт хийхэд хүндрэлтэй байдгаас шалтгаалдаг.
- 3.5.2 Харин нөгөө талаас, агаарын шугам нь харагдах байдалд илүү их нөлөө үзүүлдэг бөгөөд хүчтэй салхи, мөсний ачаалал зэрэг эрс тэс цаг уурын нөхцөлд гэмтэлд өртөх магадлал өндөр байдаг. Газар доорх шугамын хувилбар нь олон нийтэд учруулах эрсдэл (жишээлбэл, хууль бүс нэвтрэлт) бага, найдвартай ажиллагаа сайтай (цахилгаан хангамжийн богино болон урт хугацааны тасалдлын тоо цөөн), мөн реактив эсэргүүцэл бага тул хүчдэлийн уналт багатай байдаг. Гэсэн хэдий ч, кабель суурилуулсны дараа газар доорх шугамд өөрчлөлт хийх нь илүү хүндрэлтэй. Монгол Улсад агаарын шугамыг ашиглах туршлага, төслийн талбайн хөгжлийн түвшин бага, мөн өртгийн хувьд харгалзан үзэхэд агаарын шугамыг оновчтой хувилбар гэж үзэн сонгосон болно.
- 3.5.3 Нэг болон хоёр хэлхээт систем, холболтын хувилбаруудын үнэлгээ одоогоор хийгдээгүй байна. Эрчим хүчний системийн найдвартай байдлыг хангахын тулд дэд станц нь дор хаяж хоёр дамжуулах шугамтай холбогдсон байх шаардлагатай. Нэг нь орж ирэх, нөгөө нь гарах чиглэлтэй. Цахилгаан дамжуулах сүлжээний уялдаа холбоог сайжруулах нь Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг бөгөөд энэ хүрээнд хоёр хэлхээт системийг ашиглах нь дамжуулах сүлжээний найдвартай байдлыг хангах шалгуурт нийцэж байна.
- 3.5.4 Цахилгаан дамжуулах шугамын тулгуур/цамхаг/ баганын материалын хувьд мод, төмөр бетон болон ган гэсэн үндсэн сонголтууд байдаг.
- Модон багана нь харьцангуй богино зай, бага хүчдэлийн шугамд тохиромжтой. Өртөг багатай боловч ган болон бетон баганаас бат бөх чанар сул тул уг төслийн шугамын урт болон хүчдэлийн түвшинд тохиромжгүй.
 - Ган тулгуур нь бат бөх чанар сайтай, эрс тэс цаг уурын нөхцлийг тэсвэрлэх чадвартай, ашиглалтын хугацаа урт, мөн багануудын хоорондын зайг модон баганаас илүү урт байхаар төлөвлөх боломжтой. Ган тулгууруудыг жигд хэмжээтэй, олон улсын техникийн шаардлагууд болон хүлцлийн дагуу үйлдвэрлэх боломжтой. Гэсэн хэдий ч ган нь зэврэх эрсдэлтэй тул тогтмол засвар үйлчилгээ шаарддаг.
 - Төмөр бетон багана/тулгуур нь механик бат бөх чанар сайн, ашиглалтын хугацаа урт, мод болон ган баганаас илүү урт зайд суурилуулах боломжтой бөгөөд засвар үйлчилгээ бага шаарддаг. Урьдчилан хүчлэгдсэн бетон багана нь бүтцийн дагуу жигд материалын шинж чанартай, ашиглалтын хугацаанд бат бөх чанараа хадгалдаг. Гол сул тал нь хүнд жинтэй тул тээвэрлэлтийн зардал өндөр, зам, дэд бүтэц муутай бүс нутагт ажиллахад хүндрэлтэй байдаг.
- 220 кВ-ын шугамд ган тулгуур түгээмэл хэрэглэгддэг тул тус төсөлд ган тулгуурыг сонгосон.

3.5.5

- 3.5.6 Ашиглагдах цамхаг буюу тулгуурын бүтэц нь нэг хэлхээт эсвэл хоёр хэлхээт дамжуулах шугамд ашиглаж байгаа эсэх, газар нутгийн байдал, мөн тухайн бүтэц нь өлгүүр, татлага, төгсгөлийн (шугамын төгсгөлд байрлах) эсвэл байрлал солих зориулалттай эсэхээс хамаарна. Шугамын байрлал болон газар зүйн нөхцөлд тохируулан цамхагийн хэд хэдн төрөл ашиглагдахаар тодорхойлогдсон. Барилгын ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэх агаарын шугамын зураг төслийг оновчтой болгох явцад өөр төрлийн тулгуур ашиглаж болох бүс нутгуудыг тодорхойлох боломжтой

4 Хууль, стандарт, бодлогын орчин

4.1 Танилцуулга

- 4.1.1 Төсөл нь Монгол улс болон ЕСБХБ-ны байгаль орчны шаардлагад нийцэх ёстой. Дараах хэсгүүдэд төслийн хамаарах бодлого, хууль эрх зүйн болон институцийн зохицуулалтын хүрээ буюу ЕСБХБ-ны шаардлага, Монгол улсын захиргаа, хууль тогтоомж, стандарт, удирдамжуудыг тус тус авч үзнэ.

4.2 ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага

Байгаль орчин, нийгмийн бодлого

- 4.2.1 ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ), холбогдох Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь банкны бүх төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 'байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил'-ийг хангахад чиглэдэг. 2019 оны бодлого нь энэхүү төсөлд хамаарах бөгөөд байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал, нөлөөлөлд өртсөн ажилчид болон олон нийтийн эрх, холбогдох зохицуулалтын шаардлага, Олон улсын сайн туршлага (ОУСТ)-д нийцүүлэх асуудлыг төслийн үйл ажиллагааны бүх холбогдох шатанд тусгахад оршино.
- 4.2.2 БОНБ нь төслийг холбогдох ГШ, ЕХ-ны стандарт, улсын хууль тогтоомжид нийцүүлсэн байхыг шаарддаг.

Гүйцэтгэлийн шаардлага

- 4.2.3 ГШ нь бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах бат бөх үндэс суурийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг. Төслүүд нь аль болох ажилчид, олон нийт, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх ёстой. Хэрэв зайлсхийх боломжгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах, сааруулах эсвэл зохистойгоор нөхөн төлбөр олгох шаардлага үүснэ. Энэхүү төсөлд холбогдох ГШ-ыг **Хүснэгт 4-1**-д нэгтгэн харуулав. ГШ9 (Санхүүгийн зуучлагчид) нь энэ төсөлд хамаарахгүй тул тусгагдаагүй. Үүнтэй адил төслийн бүсэд уугуул иргэд байхгүй тул ГШ7 нь хамааралгүй гэж үзэж тусгаагүй болно.

Хүснэгт 4-1 ЕСБХБ-ын Гүйцэтгэлийн шаардлагууд болон тэдгээрийн төслийн холбогдох байдлын хураангуй

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
ГШ1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага	<p><u>Хураангуй</u></p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төслийн хүрээнд үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг үнэлэх үйл явцад захиалагчийн хүлээх үүрэг, мөн эдгээр эрсдэл ба нөлөөллийг удирдах, хянах журам боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийг тодорхойлно.</p> <p><u>Зорилго</u></p> <ul style="list-style-type: none"> Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг тодорхойлох, үнэлэх; Төслийн үйл ажиллагаанаас ажилчид, нөлөөлөлд өртсөн олон нийт болон байгаль орчинд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэхийн тулд эрсдэлийг бууруулах шаталсан аргачлалыг хэрэглэх; Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн түвшинд тохирсон, холбогдох ГШ-уудтай нийцсэн байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТО) боловсруулах, хэрэгжүүлэх; <p>Удирдлагын тогтолцоог үр дүнтэй ашигласнаар захиалагчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулахыг дэмжих.</p>	<ul style="list-style-type: none"> БОНИНУ Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо (БОНУТО) Байгаль орчин, нийгмийн бодлого Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө Байгууллагын чадавхи ба амлалт Нийлүүлэлтийн сүлжээний удирдлага Төслийн хяналт ба тайлагнал 	<p>Тус төсөл нь ойролцоогоор 204 км урттай шинэ агаарын цахилгаан дамжуулах шугам барих ажлыг багтааж байна. Энэ нь 2019 оны Байгаль орчны болон нийгмийн бодлогын баримт бичгийн БОНБ 2 дугаар хавсралтад заасан А ангиллын төслийн шалгуурыг хангаж байгаа тул уг төсөл А ангиллын төсөл гэж ангилагдана.</p> <p>Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны шаардлагын дагуу, А ангиллын нийтийн салбарын төслүүдэд иж бүрэн БОНИНУ хийх, түүнчлэн дор хаяж 120 хоногийн хугацаанд олон нийтэд бүрэн ил тод байдлаар танилцуулах шаардлагатай.</p> <p>Энэхүү баримт бичиг нь уг төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг танилцуулна.</p>
ГШ2: Хөдөлмөр эрхлэлт, ажиллах нөхцөл	<p><u>Хураангуй</u></p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь захиалагч болон тэдний бизнесийн үйл ажиллагаанд ажиллах хүч нь үнэт хөрөнгө болохыг хүлээн зөвшөөрч, хүний нөөцийн зөв удирдлага болон ажилчдын эрхийг хүндэтгэхэд суурилсан</p>	<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн бодлого Ажилтан–менежментийн харилцаа 	<p>Энэхүү ГШ нь голчлон төслийн барилгын үе шатанд, нэмэлт нийлүүлэгчид болон ажилчдыг ажиллуулах үед хамааралтай.</p> <p>Мөн энэ нь төслийн АЗҮ-ний үе шатны ажилд холбогдох ач холбогдолтой.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
	<p>ажилтан–менежментийн зөв харилцаа (үүнд эвлэлдэн нэгдэх эрх, хамтын хэлэлцээр хийх эрх багтана) нь бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлын гол бүрэлдэхүүн болохыг тодорхойлдог.</p> <p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> Ажилчдын үндсэн зарчим, эрхийг хүндэтгэж, хамгаалах; Ажилчдыг шударгаар харьцах, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг хангах (үндэсний хөдөлмөрийн зохистой ажлын хөтөлбөртэй нийцүүлэн); Ажилтан–менежментийн зөв харилцааг бий болгох, хадгалах, сайжруулах; Үндэсний хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомж болон захиалагчийн оролцдог аливаа хамтын гэрээг мөрдөхийг хангах; Ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилчдыг хамгаалах, ялангуяа эмзэг бүлгийн ажилчид болох залуу ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагаач ажилчид, дүрвэгсэд, гуравдагч этгээдээр дамжуулан ажил эрхэлж буй ажилчид болон захиалагчийн нийлүүлэлтийн сүлжээнд ажиллаж буй ажилчдыг хамгаалах; Албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөрийг (Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын тодорхойлолтоор) ашиглахаас урьдчилан сэргийлэх; <p>Ажилчдад ажлын байран дахь асуудлыг хөндөх, шийдвэрлэхэд хүртээмжтэй, үр дүнтэй арга хэрэгслийг бий болгохыг хангах.</p>	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн хөдөлмөр Албадан хөдөлмөр Ялгаварлан гадуурхахгүй байх ба тэгш боломж Ажилчдын байгууллага / эвлэл Цалин, хангамж ба ажлын нөхцөл Ажилчдын байр сууц / орон байр Хамтын цомхтгол Гомдол барагдуулах механизм Ажилтан бус ажилчид Нийлүүлэлтийн сүлжээ 	<p>Төслийн хөдөлмөр болон ажлын нөхцлийн нөлөөллийг энэхүү БОНИНУ-д үнэлсэн.</p> <p>БОНУТ-д Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөө болон Хөдөлмөрийн гомдол барагдуулах механизм боловсруулах шаардлагыг тусгасан.</p>
<p>ГШЗ: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх, хянах</p>	<p>Хураангуй</p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төслийн түвшинд уур амьсгалын нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгаруулалт, нөөцийн удирдлага, бохирдлоос урьдчилан сэргийлэх болон</p>	<ul style="list-style-type: none"> Нөөцийн үр ашигтай байдал Бохирдлоос урьдчилан 	<p>Барилгын ажил нь замын хөдөлгөөний нэмэгдэл, ерөнхий барилгын үйл ажиллагаа болон барилгын хог хаягдлаас үүдэн бохирдол бий болгох боломжтой.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
	<p>хяналт тавих арга барилыг тодорхойлно. Мөн энэ ГШ нь Давталттай эдийн засаг (Circular Economy)-ийн ойлголт, практикийг хүлээн зөвшөөрч, нөөцийг оновчтой ашиглах, бохирдлоос үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хянахын тулд хамгийн сайн боломжит техник болон олон улсын сайн туршлагыг ашиглахын чухлыг онцолдог.</p> <p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> Төслөөс үүдэлтэй нөөцийн ашиглалт болон бохирдлоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг шийдвэрлэхийн тулд эрсдэлийг бууруулах шаталсан аргачлал-ыг хэрэглэх; Төслийн хүрээнд үүсэх хүлэмжийн хийн (ХХ) ялгаруулалтыг зайлсхийх, багасгах, удирдах; Хорт бодис, материал (үүнд пестицид багтана)-тай холбоотой эрсдэл, нөлөөллийг зайлсхийх, багасгах, удирдах; Боломжтой тохиолдолд төслийн хүрээнд нөөцийн үр ашигтай байдлыг сайжруулах боломжийг тодорхойлох. 	<p>сэргийлэх ба хяналт</p> <ul style="list-style-type: none"> Хүлэмжийн хийн ялгарлын эх үүсвэр Ус Хог хаягдал Бохирлоос урьдчилан сэргийлэх хяналт Хүлэмжийн хий Аюултай бодис, материалын аюулгүй хэрэглээ ба удирдлага Хортон шавьжийн менежмент / хяналт 	<p>Төслийн ашиглалтын явцад цахилгаан дамжуулах шугамыг ажиллуулахад шаардлагатай эрчим хүчний хангамжаас хүлэмжийн хий шууд бус байдлаар үүсэх юм.</p> <p>Төслийн болзошгүй бохирдлын нөлөөлөл болон нөөцийн ашиглалтын асуудлыг энэхүү Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд үнэлсэн.</p> <p>Мөн Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөд төслийн хэрэгжилтийн явцад нөөцийн үр ашиг, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг тусгасан.</p>
<p>ГШ4: Эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалт</p>	<p>Хураангуй</p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор ажилчид, төслөөс нөлөөлөлд өртсөн олон нийт болон хэрэглэгчдэд учирч болзошгүй эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын эрсдэлийг эрсдэлийг хянах шаталсан аргачлалын дагуу удирдах чухлыг хүлээн зөвшөөрдөг. Захиалагч нь ажилчиддаа аюулгүй, эрүүл нөхцөлийг хангах үндсэн хариуцлагатай.</p> <p>Зорилго</p>	<p>Эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын ерөнхий шаардлага</p> <ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал Хүйсийн үндсэн дээрх хүчирхийлэл 	<p>Төслийн барилгын явцад нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалттай холбоотой сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Жишээлбэл, зам болон жимээр явах барилгын тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэх, барилгын үйл ажиллагаанаас тоосжилт ихсэх, өндөрт гүйцэтгэх барилгын ажлын эрсдэл нэмэгдэх зэрэг.</p> <p>Харин ашиглалтын явцад уг төсөл нь цахилгаан дамжуулалтын найдвартай байдлыг сайжруулах зэрэг нөлөөтэй бөгөөд энэ нь орон нутгийн</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
	<ul style="list-style-type: none"> Төслийн эрсдэлтэй холбоотойгоор аюулгүй, эрүүл, хамгаалалттай ажлын нөхцөлийг хангаж, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх замаар ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтыг хамгаалах, дэмжих; <p>Төслийн амьдралын мөчлөгийн туршид, тогтмол болон тогтмол бус үйл ажиллагаанаас үүдэлтэй эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын эрсдэлийг төслөөс нөлөөлөлд өртсөн олон нийт болон хэрэглэгчдэд тодорхойлох, үнэлэх, удирдах.</p>	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тусгай шаардлага Дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн загвар ба аюулгүй байдал Аюултай материалын аюулгүй байдал Бүтээгдэхүүний аюулгүй байдал Олон нийтийн үйлчилгээний эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл Замын хөдөлгөөн ба авто замын аюулгүй байдал Байгалийн аюул Өвчинд өртөх эрсдэл Хамгаалалт / аюулгүй байдал 	<p>бизнесүүд болон ТБЭХС-ийн хэрэглэгчдэд шууд бус байдлаар эерэг үр нөлөө үзүүлнэ.</p> <p>Өндөр хүчдэлийн шугамын ажиллагаа нь цахилгаан соронзон орны эрсдэл болон цахилгаанд цохиулах эрсдэл үүсгэж болзошгүй. Мөн засвар үйлчилгээний ажил нь бохирдлын эрсдэл болон хог хаягдал бий болгох боломжтой.</p> <p>Төслийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын эрсдлийг энэхүү Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд үнэлсэн.</p> <p>Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах шаардлагыг тусгасан.</p>
ГШ5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хориглох, албадан нүүлгэн суурьшуулах	Хураангуй <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төслийн хүрээнд газар өмчлөл, газар ашиглалттай холбоотой худалдан авалт, шилжүүлэлтээс үүдэх нөлөөллийг хамаарна. Энэ ГШ-ийн хэрэгжилт нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, сахин</p>	<ul style="list-style-type: none"> Нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх эсвэл хамгийн бага түвшинд байлгах 	<p>Энэхүү ГШ нь шинэ ЦДАШ болон түүний хамгаалалтын зурваст шаардлагатай газар, түүнтэй холбоотой биеийн болон эдийн засгийн шилжилт хөдөлгөөнд хамаарна.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
	<p>биелүүлэх зарчимтай нийцэж, ялангуяа хувийн өмчийн эрх, зохистой орон сууцны эрх, амьдрах нөхцөлийг тасралтгүй сайжруулах эрхийг хангахад чиглэнэ.</p> <p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> Албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх, зайлшгүй тохиолдолд төслийн боломжит өөр хувилбар загвар, байршлыг судалж, албадан нүүлгэн суурьшуулалтыг хамгийн бага түвшинд байлгах; Албадан хөөн гаргалтаас зайлсхийх; Албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлшгүй үүсэх сөрөг нийгмийн болон эдийн засгийн нөлөөллийг бууруулахын тулд: <ol style="list-style-type: none"> Хөрөнгийн алдагдлыг бүрэн нөхөн төлөх өртгөөр цаг тухайд нь нөхөн олговор олгох; 2. Газар худалдан авах, газар ашиглалтад хязгаарлалт тогтоох, бусад хөрөнгө, байгалийн нөөц болон албадан нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг ГШ10-ийн шаардлагын дагуу бодитой зөвлөлдөх, оролцуулах, мэдээлэл ил тод болгох замаар хэрэгжүүлэх; Нүүлгэн суурьшуулалтад өртсөн иргэдийн амьжиргаа, амьдралын түвшинг дор хаяж өмнөх түвшинд нь сэргээх, эсвэл сайжруулах; Бие махбодын хувьд нүүлгэн шилжүүлэгдсэн иргэдийн амьдрах нөхцөлийг хангалттай орон сууц (үндсэн үйлчилгээ, дэд бүтэц багтсан) болон эзэмших эрхийн баталгаатайгаар шинэ суурьшлын газарт сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> Албадан хөөн гаргалтаас зайлсхийх Хэлэлцээрийн замаар шийдвэрлэх Эмзэг бүлгийг харгалзан үзэх Хүйсийн асуудлыг харгалзан үзэх Нийгэм-эдийн засгийн судалгаа Өртсөн хөрөнгийн тооллого, бүртгэл ба таслах огноо Өртсөн газар болон хөрөнгийн үнэлгээ Эрхийн ангилал Өртсөн иргэдэд олгох нөхөн төлбөр ба ашиг тус Сайн дурын газар хандивлах Олон нийтийн байгууламж, дэд бүтэц, нийтийн үйлчилгээний алдагдал Оролцогч талуудын оролцоо Гомдол барагдуулах механизм 	<p>Шилжилт хөдөлгөөний нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийж, энэхүү Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон Газрын шилжилт хөдөлгөөний хүрээний баримт бичигт тусгасан.</p> <p>Энэхүү ГШ нь голчлон барилгын үе шатанд үүсэж болзошгүй бага түвшний эдийн засгийн сааталтай холбоотой. Хамгаалалтын зурваст малчдын сууц (гэрийн бууц) тогтоогдоогүй боловч малчин өрхүүд нүүдэлчин шинжтэй тул барилгын өмнө нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.</p> <p>Одоогоор түр хугацаанд газар ашиглах боломж хязгаарлагдсанаар амьжиргаанд нөлөөлөхгүй гэж үзэж байна. Гэвч маршрутын байнгын зурвас нь 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамарч, 3 орон нутгийн хамгаалалттай газрыг дайран өнгөрнө.</p> <p>Энэхүү БОНИНУ ил тод байдлын багцын хүрээнд ГЧНШХХ боловсруулсан. Маршрутын эцсийн хамгаалалтын зурвасыг нарийвчлан судалж, шаардлагатай тохиолдолд Газрын шилжилт хөдөлгөөний төлөвлөгөө болон/эсвэл Амьжиргаа сэргээх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Барилгын гүйцэтгэгч нь түр барилгын талбайг аль болох гэрээ хэлцэл болон сайн дурын арилжаанд тулгуурлан сонгох ёстой. Хэрэв энэ боломжгүй бол захиалагч болон гүйцэтгэгч нь түр хугацааны шилжилт хөдөлгөөний нөлөөллийг НСҮАТ/АНСТ-ийн хүрээнд үнэлэх шаардлагатай.</p> <p>Гүйцэтгэгч нь газарт нэвтрэх болон гарах протоколыг мөрдөж, газар ашиглалтын нөхцөл байдлыг нэвтрэх болон гарах үед баримтжуулан, захиалагчид тайлагнах ёстой.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
		<ul style="list-style-type: none"> • Төлөвлөлт ба хэрэгжилт • Байгууллагын чадавхи ба амлалт • Хяналт ба үнэлгээ • Бие махбодын нүүлгэн суурьшуулалт ба дахин суурьшуулах дэмжлэг 	
ГШ6: Биологийн олон янз байдлын хадгалалт, байгалийн амьд нөөцийн тогтвортой удирдлага	<p><u>Хураангуй</u></p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийг тогтвортой удирдах нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын үндэс суурь болохыг хүлээн зөвшөөрдөг. ГШ10-ийн зорилгууд нь биологийн олон янз байдал болон амьд байгалийн нөөцийн эдийн засаг, нийгэм, соёлын олон талын үнэ цэнийг оновчтой ашиглах боломжтой байдлыг тэнцвэржүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p><u>Зорилго</u></p> <ul style="list-style-type: none"> • Биологийн олон янз байдлыг урьдчилан сэргийлэх аргачлалаар хамгаалах, хадгалах; • Төслийн загвар, хэрэгжилтэд эрсдэлийг бууруулах шаталсан аргачлал-ыг хэрэгжүүлж, биологийн олон янз байдлын алдагдлыг үгүйсгэх, шаардлагатай тохиолдолд нэмэгдүүлэх; • Экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах; • Амьд байгалийн нөөцийг тогтвортой удирдах, ашиглахад олон улсын сайн туршлагыг дэмжих. 	<p>Биологийн олон янз байдлыг хамгаалах</p> <ul style="list-style-type: none"> • Асуудал ба нөлөөллийн үнэлгээ • Биологийн олон янз байдал, тэргүүлэх ач холбогдол бүхий шинж чанар болон чухал амьдрах орчныг хамгаалах, хадгалах • Хууль ёсоор хамгаалагдсан болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн биологийн үнэ цэн бүхий газар нутаг • Гадаад гаралтай түрэмгий зүйлс 	<p>Төслийн байршилд ургамлын бүрхэвчийг цэвэрлэх шаардлага гарч болзошгүй. Барилгын явцад замын хөдөлгөөн нэмэгдэх, дуу чимээ, агаарын бохирдол зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй. Ашиглалтын үе шатанд шувууд мөргөлдөх эрсдэл нэмэгдэх боломжтой.</p> <p>Төслийн эдгээр газарт үзүүлэх нөлөөллийг энэхүү БОНИНУ-д үнэлсэн.</p> <p>БОНУТ-д амьдрах орчин болон зүйлийн болзошгүй нөлөөллийг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг санал болгосон.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
		<ul style="list-style-type: none"> Амьд байгалийн нөөцийг тогтвортой удирдах Нийлүүлэлтийн сүлжээ 	
ГШ8: Соёлын өв	<p><u>Хураангуй</u></p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь соёлын өвийг одоо болон ирээдүй үеийнхэнд хамгаалах чухлыг хүлээн зөвшөөрдөг. Биет болон биет бус соёлын өв нь эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хөрөнгө бөгөөд соёлын үнэлэмжийн салшгүй хэсэг юм. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхдээ энэхүү ГШ нь холбогдох олон улсын конвенцоор удирдуулна.</p> <p><u>Зорилго</u></p> <ul style="list-style-type: none"> Соёлын өвийг хамгаалах, хадгалахад дэмжлэг үзүүлэх; Төслөөс үүдэлтэй сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалахад эрсдэлийг бууруулах шаталсан аргачлал-ыг хэрэглэх; Соёлын өвийг бизнесийн үйл ажиллагаанд ашиглахдаа үр өгөөжийг шударгаар хуваарилахыг дэмжих; <p>Соёлын өвийн чухал элементүүдийг тодорхойлсон тохиолдолд, соёлын өвийн талаарх мэдлэг, үнэлэмж, сайжруулалтыг дэмжихийн зэрэгцээ орон нутгийн олон нийтэд эдийн засаг, нийгмийн боломжит ашиг тусыг бий болгох.</p>	<ul style="list-style-type: none"> Нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх Эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ Санамсаргүй олдворын журам Хууль ёсоор хамгаалагдсан болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн газар нутаг Төслийн хүрээнд соёлын өвийг ашиглах 	<p>Төслийн хэрэгжилтийн явцад мэдэгдэж буй соёлын өвд шууд нөлөөлөл үзүүлэхгүй. Гэвч төслийн талбайд одоогоор тодорхойгүй соёлын өв байж болзошгүй тул Санамсаргүй олдворын журмыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж, Байгаль орчин, нийгмийн удирдлагын болон хяналтын төлөвлөгөөд тусгасан.</p> <p>Барилгын ажил эхлэхийн өмнө ЭХЯ-аас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу археологийн судалгааг хийж, одоогоор тодорхойгүй байгаа газрын гүнд орших археологийн дурсгалуудыг илрүүлэх шаардлагатай. Судалгааны үр дүн нь тухайн бүсэд барилгын ажил эхлэхийн өмнө хэрэгжүүлэх археологийн малтлага болон баримтжуулалтын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох үндэслэл болно..</p>
ГШ10: Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоог хангах	<p><u>Хураангуй</u></p> <p>Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь захиалагч, түүний ажилчид, ажилчдын төлөөлөгчид, орон нутгийн олон нийт болон төслөөс нөлөөлөлд өртсөн иргэд, шаардлагатай тохиолдолд бусад оролцогч талуудын хооронд нээлттэй, ил</p>	<ul style="list-style-type: none"> Оролцогч талуудыг тодорхойлох Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө 	<p>Ангилал А-д хамаарах нийтийн салбарын төслүүдэд иж бүрэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай бөгөөд түүнчлэн дор хаяж 120 хоногийн хугацаанд олон нийтэд ил тод байдлаар танилцуулах ёстой.</p>

Гүйцэтгэлийн шаардлага	Хураангуй, зорилго	Хамрах хүрээ	Холбогдох байдал, нийцэл
	<p>тод оролцоог хангах нь олон улсын сайн туршлага болон байгууллагын нийгмийн хариуцлагын салшгүй элемент болохыг хүлээн зөвшөөрдөг. Ийм оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн болон нийт тогтвортой байдлыг сайжруулах нэг арга зам юм.</p> <p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> Захиалагчид оролцогч талуудтайгаа бүтээлч харилцаа тогтоож, хадгалахад туслах системтэй оролцооны аргачлалыг тодорхойлох; Төслийн амьдралын мөчлөгийн туршид оролцогч талуудтай үр дүнтэй, хүртээмжтэй оролцоог хангах арга хэрэгслийг бий болгох; Байгаль орчин, нийгмийн холбогдох мэдээллийг ил тод болгох, төслийн оролцогч талуудтай бодитой зөвлөлдөх, шаардлагатай тохиолдолд зөвлөлдөх явцад гарсан санал, шүүмжийг харгалзан үзэх; <p>Оролцогч талаас гарсан гомдолд зохих ёсоор хариу өгөх, зохистойгоор удирдах.</p>	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл ил тод болгох Бодитой зөвлөлдөх А ангиллын төслүүдийн мэдээлэл ил тод болгох ба зөвлөлдөх Гомдол барагдуулах механизм Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн өөрчлөлтүүд 	<p>Энэхүү баримт бичиг нь уг төслийн БОНИНУ-г танилцуулж байна.</p> <p>Талуудын оролцоог ТОХТ-д тусгасан болно..</p>

Холбогдох ЕХ-ны удирдамж

- 4.2.4 ЕСБХБ-ны БОНБ-ын хүрээнд төсөл нь холбогдох ЕХ-ны үндсэн байгаль орчны стандартуудыг мөрдөх шаардлагатай. Холбогдох ЕХ-ны удирдамжууд нь дараах байдалтай байна:

**2011/92/ЕХ Удирдамж – Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, 2014 онд
2014/52/ЕХ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний удирдамжаар
шинэчлэн найруулсан.**

- 4.2.5 Төслийн хувьд хамгийн их холбогдох ЕХ-ны удирдамж нь 2011/92/ЕХ байна. Энэ нь зарим төрийн болон хувийн төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх тухай бөгөөд 2014/52/ЕХ удирдамжаар (БОНУ удирдамж) шинэчлэгдсэн. Энэхүү удирдамж нь байгаль орчны хамгаалалтын түвшинг сайжруулж, төрийн болон хувийн хөрөнгө оруулалтын шийдвэрийг урт хугацаанд илүү оновчтой, урьдчилан таамаглах боломжтой, тогтвортой болгох зорилготой. I хавсралтад багтсан бүх төслүүдэд БОНУ заавал хийгдэх бөгөөд II хавсралтад багтсан төслүүдийн хувьд БОНУ хийх эсэхийг үндэсний эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ. Мөн энэ удирдамж нь шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн үр дүнтэй оролцоог хангах, соёлын өвийг хамгаалах, дэмжих, олон нийтийн мэдээлэлд хандах боломжийг бэхжүүлэх шаардлагыг нэмэгдүүлнэ.

- 4.2.6 Төсөл нь дараах шинж чанарууд хамаарах тул БОНУ удирдамжийн I хавсралтад багтана:

"220 кВ болон түүнээс дээш хүчдэлийн, 15 км-ээс урт агаарын цахилгаан дамжуулах шугам барих." I хавсралт, 4(1) дүгээр зүйл."

- 4.2.7 БОНУ удирдамж болон түүний нэмэлт өөрчлөлтүүд нь шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн үр дүнтэй оролцоог (биологийн олон янз байдлын нөлөөллийг хамруулан) хангах шаардлагыг онцлохоос гадна холбоод, байгууллагууд, ялангуяа төрийн бус байгууллагуудын оролцоог ч мөн шаарддаг. Мөн олон нийтийн мэдээлэлд хандах боломж, ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор байгаль орчны мэдээллийг цаг тухайд нь цахим хэлбэрээр хүртээмжтэй болгох шаардлагатай байдаг байна. Тус удирдамжийн шаардлагаар нөлөөллийн үнэлгээний баримт бичгийг олон нийтийн санал авах зорилгоор ил тод болгоход чиглэсэн байдаг. Олон нийт зөвлөгөөнд бэлтгэх, оролцох боломжийг хангахуйц зохистой хугацааг олгох ёстой. Зөвлөгөөний үр дүнг тэмдэглэн авч, төслийн хэрэгжилтийн явцад харгалзан үзэх шаардлагатай.

- 4.2.8 2014 оны удирдамжийн нэмэлт өөрчлөлтүүд нь соёлын өвийг хамгаалах, дэмжихэд (экологийн ач холбогдол бүхий байгалийн экосистемийг багтааж болно) илүү их анхаарал хандуулж, олон нийтийн мэдээлэлд хандах боломжийг бэхжүүлжээ.

2000/60/ЕХ Удирдамж – Усны хүрээний удирдамж

- 4.2.9 Энэхүү удирдамжийн зорилго нь гол, нуур зэрэг дотоодын гадаргын ус, шилжилтийн ус (голын амсрын хэсэг), эргийн ус болон газрын доорх усыг хамгаалах хүрээг тогтооход оршино. Үүнээс гадна усны нөөцийг үр ашигтай ашиглах, бүх усны экосистем болон тэдгээрийн усны хэрэгцээтэй холбоотой хуурай газрын экосистем, намгархаг газруудыг 2015 он гэхэд 'сайн төлөв'-т хүргэхийг зорьсон. Энэхүү удирдамж нь амьдрах орчны хувьд чухал усны нөөцийг

тогтвортой удирдлагад оруулах замаар биологийн олон янз байдалд шууд холбогдох ач холбогдолтой. Төслийн төлөвлөсөн агаарын цахилгаан дамжуулах шугамын маршрутын дагуу байнгын гадаргын усны биет байхгүй гэж ойлгогдож байгаа боловч талбайн урьдчилсан үзлэгийн явцад хэд хэдэн хуурай голын сайр илэрсэн. Судалгааны бүсэд Сайншандын ойролцоо газрын доорх усаар тэжээгддэг гэж үзэж буй намгархаг газар байгаа бөгөөд мөн Өөшийн говийн хамгаалалттай бүсийн 150–155 км-ийн хэсэгт усан сан байх боломжтой гэж үзсэн байна.

2009/147/ЕХ Удирдамж – Зэрлэг шувуудыг хамгаалах тухай

- 4.2.10 Зэрлэг шувуудыг хамгаалах тухай ЕХ-ны удирдамж (2009/147/ЕХ), буюу 'Шувуудын удирдамж' нь холбогдох ач холбогдолтой. 1 дүгээр зүйл нь уг удирдамжийг Гэрээ үйлчилж буй гишүүн улсуудын нутаг дэвсгэрт байгальд өөрийн жамаар оршин тогтнож буй бүх төрлийн шувуудыг хамгаалахад чиглэдэг. Энэ нь эдгээр төрөл зүйлийг хамгаалах, удирдах, хянах, ашиглах журам тогтоох бөгөөд шувууд, тэдгээрийн өндөг, үүр болон амьдрах орчинд хамаарна. 5 дугаар зүйл нь үүр, өндгийг хамгаалах, ялангуяа үржлийн болон дэгдээхэй бойжуулах хугацаанд эдгээр шувуудыг санаатайгаар саад учруулахыг хориглодог бөгөөд уг саад нь удирдамжийн зорилгод нийцүүлэн чухал нөлөөтэй байх тохиолдолд хамаарна. Мөн уг удирдамж нь шувуудын зүйл болон тэдгээрийн амьдрах орчныг тогтвортой удирдах дүрмийг хамруулдаг.

92/43/ЕЕХ Удирдамж – Байгалийн амьдрах орчин болон зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах тухай

- 4.2.11 Байгалийн амьдрах орчин болон зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах тухай ЕХ-ны удирдамж (92/43/ЕЕХ), өөрөөр хэлбэл 'Амьдрах орчны удирдамж' нь холбогдох ач холбогдолтой. Энэхүү удирдамж нь 'Шувуудын удирдамж'-тай хамт ЕХ-ны зэрлэг амьтан, байгаль хамгаалалтын тогтолцооны гол тулгуур багануудын нэгт тооцогдоно. Удирдамжийн 17 дугаар зүйл нь тусгайлан жагсаасан амьдрах орчин болон зүйлүүдийн талаар ЕХ-ны гишүүн орнуудын тайлагнах нөхцөл, стандартыг тогтоосон. Мөн удирдамжийн хавсралтуудад хамгаалагдсан амьдрах орчин болон зүйлүүдийг тодорхойлсон байдаг:

- I хавсралт – Амьдрах орчныг хамарна
- II хавсралт – Тусгай хамгаалалтын бүсээр тодорхойлох шаардлагатай зүйлүүд
- IV хавсралт – Хатуу хамгаалалт шаардлагатай зүйлүүд
- V хавсралт – Гишүүн орнууд хүн амын тоог хэрхэн удирдахыг өөрсдөө шийдэх боломжтой зүйлүүд

2003/4/ЕХ Удирдамж – Байгаль орчны мэдээлэлд олон нийт хандах эрхийн тухай

- 4.2.12 Энэхүү удирдамжийн зорилго нь байгаль орчны мэдээллийг системтэйгээр олон нийтэд хүртээмжтэй болгож, түгээхэд оршино. Удирдамж нь гишүүн орнуудад олон нийтийн байгууллагууд өөрийн эзэмшиж буй байгаль орчны мэдээллийг хүсэлт гаргасан аливаа хуулийн этгээд болон иргэнд олгох шаардлага тавьдаг.

2008/98/ЕХ Удирдамж – Хог хаягдлын хүрээний удирдамж

- 4.2.13 Хог хаягдлын хүрээний удирдамж нь хог хаягдлын менежментийн үндсэн зарчмуудыг тогтооно. Энэ нь хог хаягдлыг хүний эрүүл мэндэд аюулаас сэргийлэх, байгаль орчинд хохиролоос

зайлсхийх; ус, агаар, хөрс, ургамал, амьтанд эрсдэлд өртөхгүй байх; дуу шуугиан болон үнэрээр олон нийтэд хүндрэл болгохгүй байх; мөн хөдөө орон нутаг болон тусгай ач холбогдол бүхий газруудад сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлага тавьсан байдаг.

- 4.2.14 Энэ нь хог хаягдлыг хог гэхгүйгээр хоёрдогч түүхий эд болох үеийг тайлбарлар, хог хаягдал болон дайвар бүтээгдэхүүнийг хэрхэн ялгах тухай тодорхойлон тусгасан байдаг. Мөн уг удирдамж нь 'бохирдуулсан этгээд төлөх зарчим' болон 'өргөтгөсөн үйлдвэрлэгчийн хариуцлага'-ын зохицуулалт орсон байдаг.
- 4.2.15 ЕХ-ны хог хаягдлын менежментийн үндэс нь Хог хаягдлын хүрээний удирдамжаар тогтоосон таван шатлал бүхий 'хог хаягдлын шатлал' юм. Энэ нь хог хаягдлыг удирдах, зайлуулахад давуу эрхийн дарааллыг зохицуулсан байна.

89/391/ЕЕХ Удирдамж – Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай

- 4.2.16 Энэхүү хүрээний удирдамж нь ажилчдын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулахыг дэмжих үндсэн зарчмуудыг тогтоодог. Энэ нь Европ даяар аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгийн бага шаардлагыг баталгаажуулдаг бөгөөд гишүүн орнуудад илүү чангатгасан арга хэмжээ авах, шинээр тогтоох боломжтой байна.

89/654/ЕЕХ Удирдамж – Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлагын доод хэмжээг тогтоох тухай

- 4.2.17 Энэхүү удирдамж нь дээр дурдсан 89/391/ЕЕХ Хүрээний удирдамжийн 16 дугаар зүйлийн утга санааны дагуу гарсан анхны тусгай удирдамж юм. Удирдамж нь 'ажлын байр' гэдгийг аж ахуйн нэгжийн болон/эсхүл байгууллагын байранд ажлын станцуудыг байрлуулах зориулалттай газар, мөн ажилтан өөрийн ажлын явцад нэвтрэх боломжтой тухайн аж ахуйн нэгжийн болон/эсхүл байгууллагын бусад газрыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Ажил олгогчид ажлын байр нь удирдамжийн хавсралтад заасан аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгийн бага түвшинг тогтоосон шаардлагыг хангана. Үүнд: яаралтай гарц, гарцын зам; гал илрүүлэх, унтраах; хаалттай ажлын байрны агааржуулалт; өрөөний температур; өрөөний байгалийн болон хиймэл гэрэлтүүлэг; жирэмсэн эмэгтэйчүүд ба хөхүүл эхчүүд; ариун цэврийн тоног төхөөрөмж; анхны тусламжийн өрөө/тоног төхөөрөмж; хөгжлийн бэрхшээлтэй ажилчид зэрэг сэдвүүдийг агуулсан байдаг.

Европын парламент болон Зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 2013/35/ЕХ Удирдамж – Ажилчид физик хүчин зүйлс (цахилгаан соронзон орон)-оос үүсэх эрсдэлд өртөхтэй холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгийн бага шаардлагын тухай (89/391/ЕЕХ Удирдамжийн 16(1) дугаар зүйлийн утга санааны дагуу гарсан 20 дахь тусгай удирдамж) бөгөөд 2004/40/ЕЕХ Удирдамжийг хүчингүй болгосон (Цахилгаан соронзон орны хүрээний удирдамж).

4.2.18 Энэхүү удирдамж нь цахилгаан соронзон орноос үүсэх бүх мэдэгдэж буй шууд биофизикийн нөлөө болон бусад шууд бус нөлөөг хамардаг. Удирдамж нь одоогоор зөвхөн богино хугацааны нөлөөг авч үздэг бөгөөд урт хугацааны боломжит нөлөөг харгалзан үздэггүй.

4.2.19 Ажил олгогч нь Хүрээний удирдамжийн зарчмуудын дагуу ажлын байранд цахилгаан соронзон орноос (ЦСО) үүсэх эрсдэлийг арилгах эсвэл хамгийн бага түвшин хүртэл бууруулах ёстой. Хэрэв холбогдох үйлдлийн түвшин болон өртөлтийн хязгаарын утгууд хэтрэх магадлалтай бол ажил олгогч эдгээрийг хэтрүүлэхгүй байлгахын тулд үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх шаардлагатай болно. Хязгаарын утгад тодорхой хөнгөлөлтүүд хамаарна.

4.2.20 Энэ нь ажлын байранд ЦСО-ны эрсдэлийн үнэлгээг (шаардлагатай бол хэмжилт болон тооцооллыг багтаан) Хүрээний удирдамжийн дагуу хийхийг шаарддаг. Хөдөлмөрийн өртөлтийн үнэлгээ нь олон нийтэд зориулсан үнэлгээ аль хэдийн хийгдсэн бөгөөд тухайн тоног төхөөрөмж нь олон нийтийн хэрэглээнд зориулагдсан тохиолдолд шаардагдахгүй. Ажилчид мэдрэлийн тогтолцоотой холбоотой түр зуурын шинж тэмдгийг мэдээлсэн тохиолдолд ажил олгогч эрсдэлийн үнэлгээ болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинэчлэхийг авч үзэх ёстой.

Эрчим хүчний үр ашигтай хэрэглээний тухай Европын парламент болон Зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 2012/27/ЕХ Удирдамж

4.2.21 ЕХ-ны Эрчим хүчний үр ашигтай хэрэглээний тухай удирдамж нь шууд хэрэгжихгүй боловч зарим заалт нь холбогдох ач холбогдолтой. Тухайлбал, 15 дугаар зүйл нь эрчим хүчний хувиргалт, дамжуулалт болон түгээлтийг хамардаг. Энэ нь цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн үр ашигтай байдлын боломжийг үнэлэхийг шаарддаг бөгөөд ялангуяа дамжуулалт, түгээлт, ачааллын удирдлага, харилцан уялдаа болон эрчим хүч үйлдвэрлэх байгууламжид холбогдох асуудлыг хамардаг. Мөн 15 дугаар зүйл нь сүлжээний дэд бүтцэд зардал багатай эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх тодорхой арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацааг тогтоохыг шаардсан байдаг байна.

ЕХ-ны Зөвлөлийн зөвлөмж (1999/519/ЕХ)

Холбогдох конвенц

4.2.22 Монгол улс байгаль орчинтой холбоотой Error! Reference source not found.-д тусгасан олон улсын хэд хэдэн конвенцод нэгдэн орсон байдаг.

Хүснэгт 4-2 Монгол Улсын нэгдэн орсон олон улсын байгаль орчны болон соёлын өвийн конвенцууд

#	Конвенц	Нэгдэн орсон жил
Байгаль орчны конвенцууд		
1	Биологийн олон янз байдлын тухай конвенц	1993
2	Биологийн аюулгүй байдлын тухай Картахена протокол	2000
3	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБҮАӨСК)	1994

#	Конвенц	Нэгдэн орсон жил
4	Киотогийн протокол	1999
5	Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц	1996
6	Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувуудын амьдрах орчныг хамгаалах тухай конвенц (Рамсарын конвенц)	1998
7	Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц	1996
8	Озоны давхаргыг доройтуулах бодисыг зохицуулах тухай Монреалын протокол	1996
9	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)	1996
10	Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөний тухай конвенц (Базелийн конвенц)	1997
11	Олон улсын худалдаанд ашиглагддаг тодорхой аюултай химийн бодис, пестицидийн талаар урьдчилан мэдээлсэн зөвшөөрлийн журамтай холбоотой Роттердамын конвенц	2001
12	Үргэлжилсэн органик бохирдуулагчдын тухай Стокгольмын конвенц	2004
13	Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц	1999
14	Африк болон Евразид нүүдлийн махчин шувуудыг хамгаалах тухай Санамж бичиг (MoU)	2008
15	Парисын уур амьсгалын өөрчлөлтийн тухай хэлэлцээр	2016
Соёлын өвийн конвенц		
16	"Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах тухай конвенц	1964
17	Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц	1990
18	Соёлын өвийн хууль бус нэвтрэлт, гаргалтыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мөн соёлын өвийн өмчлөл шилжүүлэхийг хориглох тухай конвенц	1991
19	Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц	2005
20	Соёлын илэрхийллийн олон янз байдлыг хамгаалах, дэмжих тухай конвенц	2007

Эх сурвалж: БОНУНУ-ий баг.

- 4.2.23 Монгол улс уг конвенцид нэгдээгүй хэдий ч ЕСБХБ нь Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах, шударга ёсны хүртээмжийг бий болгох тухай Орхусын конвенц, мөн хил дамнасан нөхцөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай Эспогийн конвенцийг баримтална.

Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах, шударга ёсны хүртээмжийг бий болгох тухай 1998 оны Орхусын конвенц

- 4.2.24 Орхусын конвенц нь байгаль орчны асуудалтай холбогдуулан олон нийт (хувь хүн болон тэдгээрийн холбоод)-д хэд хэдэн эрхийг олгодог. Уг конвенц дараах эрх тусгагдсан:

- **Байгаль орчны мэдээлэлд хандах эрх:** Хүн бүр төрийн байгууллагад хадгалагдаж буй байгаль орчны мэдээллийг авах эрхтэй. Хүсэлт гаргасан иргэн уг мэдээллийг хүсэлт гаргаснаас хойш нэг

сарын дотор авах эрхтэй бөгөөд яагаад шаардлагатайг тайлбарлах шаардлагагүй. Үүнээс гадна төрийн байгууллагууд өөрийн мэдэлд буй байгаль орчны мэдээллийг идэвхтэйгээр олон нийтэд түгээх үүрэгтэй.

- **Байгаль орчны шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоо:** Байгаль орчны шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг хангана. Төрийн байгууллагууд байгаль орчны төсөл, төлөвлөгөө, хөтөлбөрийн саналд олон нийт болон байгаль орчны төрийн бус байгууллагуудын санал бодлыг илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалт хийх ёстой. Гаргасан санал, шүүмжийг шийдвэр гаргах явцад харгалзан үзэх бөгөөд эцсийн шийдвэр болон түүний үндэслэлийг олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- **Шударга ёсны хүртээмж:** Байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн, эсвэл дээр дурдсан хоёр эрхийг хангаагүйгээр гаргасан төрийн байгууллагын шийдвэрийг давж заалдах, хянан үзүүлэх эрхийг хангана.

Хил дамнасан нөхцөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай 1991 оны Эспогийн конвенц

- 4.2.25 Эспогийн (БОНУ) конвенц нь тодорхой үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг төлөвлөлтийн эхний шатанд үнэлэх үүргийг Гишүүн орнуудад тогтоож өгдөг. Мөн хил дамнасан байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай томоохон төслүүдийг хэлэлцэж буй тохиолдолд улс орнууд харилцан мэдэгдэх, зөвлөлдөх ерөнхий үүргийг тогтоож өгдөг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай 1990 оны конвенц

- 4.2.26 32.1 дүгээр зүйлийн дагуу хүүхэд нь эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалагдах, мөн хүүхдийн боловсролд саад учруулах, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаа, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд хортой байж болзошгүй аливаа ажил хөдөлмөр эрхлэхээс хамгаалагдах эрхтэй.
- 4.2.27 1999 онд Европын Холбооны Зөвлөл (ЕХ) олон нийтийг цахилгаан соронзон орон (0 Гц–300 Гц)-д өртөхийг хязгаарлах тухай зөвлөмжийг (1999/519/ЕХ) нийтэлсэн. Энэхүү зөвлөмж нь Цацраг идэвхгүй цацрагийн олон улсын хамгаалалтын комиссын (ICNIRP) 300 Гц хүртэлх хугацааны хувьд өөрчлөгдөх цахилгаан, соронзон болон цахилгаан соронзон оронд өртөхийг хязгаарлах удирдамжид үндэслэсэн. Уг зөвлөмжийн дагуу өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын (50 Гц) лавлагаа утгууд нь: цахилгаан орон – метр тутамд 5 киловольт (5 kV/m), соронзон орон – 100 микротесла (100 μT) байна.

Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын конвенцууд

4.2.28 Монгол Улс 1968 оноос Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) гишүүн бөгөөд нийт 20 конвенцыг соёрхон баталсан. Үүнээс 18 нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд бүх найман үндсэн конвенцыг багтаасан. Харин нэг конвенцыг хүчингүй болгосон. Соёрхон баталсан конвенцуудыг **Хүснэгт 4-3**-т жагсаав.

Хүснэгт 4-3 Монгол Улсын соёрхон баталсан ОУХБ-ын конвенцууд

Конвенцийн нэр	Монгол Улсын соёрхон баталсан огноо
Нэгдлийн эрх чөлөө, хамтын хэлэлцээр, аж үйлдвэрийн харилцаа	
C087 – Холбоо байгуулах эрх чөлөө болон холбоо байгуулах эрхийг хамгаалах тухай конвенц, 1948 (No.87)	1969 оны зургаадугаар сарын 3
C098 – Холбоо байгуулах болон хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай конвенц, 1949 (No.98)	1969 оны зургаадугаар сарын 3
C135 – Ажилчдын төлөөлөгчдийн тухай конвенц, 1971 (No.135)	1996 оны аравдугаар сарын 8
Албадан хөдөлмөр	
C029 – Албадан хөдөлмөрийн тухай конвенц, 1930 (No.29)	2005 оны гуравдугаар сарын 15
C105 – Албадан хөдөлмөрийг устгах тухай конвенц	2005 оны гуравдугаар сарын 15
Хүүхдийн хөдөлмөрийг устгах, хүүхэд, залуучуудыг хамгаалах	
C123 – 1965 оны 123 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэх доод нас (газар доорх ажил) — тогтоосон доод нас: 18 нас,	1981 оны арванхоёрдугаар сарын 3
C138 – Хөдөлмөр эрхлэх доод насыг тогтоох тухай конвенц 1973 (No.138)	2002 оны арванхоёрдугаар сарын 16
C182 – Хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг устгах тухай конвенц, 1999 (No.182)	2001 оны хоёрдугаар сарын 26
Тэгш боломж, хандлага	
C100 – Цалин хөлсний тэгш байдлын тухай конвенц, 1951 (No.100)	1969 оны зургаадугаар сарын 3
C111 – Ажил эрхлэлт болон мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуурхах тухай конвенц, 1958 (No.111)	1969 оны зургаадугаар сарын 3
Ажил эрхлэлтийн бодлого ба сурталчилгаа	

Конвенцийн нэр	Монгол Улсын соёрхон баталсан огноо
C088 – Ажил эрхлэлтийн үйлчилгээний конвенци, 1948 (No.88)	2015 оны дөрөвдүгээр сарын 17
C122 – Хөдөлмөрийн бодлогын конвенц, 1964 (No.122)	1976 оны арваннэгдүгээр сарын 24
C159 – Мэргэжлийн сэргээн засах ба ажиллуулах (Хөгжлийн бэрхшээлтэй иргэд)-ийн Конвенци, 1983 (No.159)	1998 оны хоёрдугаар сарын 3
C181 – Хувийн хөдөлмөрийн агентлагийн тухай конвенц, 1997 (No.181)	2015 оны дөрөвдүгээр сарын 17
Ажлын аюулгүй байдал, эрүүл мэнд	
C155 – Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын конвенц, 1981 (No.155)	1998 оны хоёрдугаар сарын 3
C176 - Уурхайн аюулгүй байдал, эрүүл мэндийн конвенц, 1995 (No.176)	2015 оны Арваннэгдүгээр сарын 26
Эхийн хамгаалалт	
C103 – Эхийн хамгаалах тухай конвенц, 1952 (No.103)	1969 оны зургаадугаар сарын 3
Гурван талт зөвлөх	
C144 – Олон улсын хөдөлмөрийн стандартын гурван талт зөвлөлдөх конвенц, 1976 (No.144)	1998 оны наймдугаар сарын 10

Эх сурвалж: ОУХБ

Монгол улсын бодлого, эрх зүйн зохицуулалтын хүрээ

Байгаль орчин, нийгмийн бодлого

Алсын хараа 2050

4.2.29 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050” нь ядуурлыг бууруулах, илүү хүртээмжтэй эдийн засгийн өсөлтөд шилжихэд онцгой анхаарал хандуулдаг. Тогтвортой хөгжлийг “Алсын хараа 2050”-д нийгмийн хөгжилтэй уялдуулан тодорхойлсон бөгөөд үүнд жендэрийн тэгш байдал, амьдралын чанарыг дээшлүүлэх, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах зэрэг асуудлыг хамруулсан байна.

4.2.30 “Алсын хараа 2050”-ийн гол чиглэлүүд нь харилцан уялдаа холбоотой бөгөөд хөгжлийн хүчин чармайлтыг харилцан дэмжих зорилготой. Нэн тэргүүний чиглэлүүд нь: Нийтийн үндэсний үнэт зүйлс, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга бүхий нийгэм, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Бүс нутгийн хөгжил. Эдгээр стратегийн тэргүүлэх чиглэлүүд нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай (ТХЗ) өргөн хүрээнд нийцэж байна.

Шинэ сэргэлтийн бодлого, 2021

4.2.31 Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 3 дугаар сард баталсан “Шинэ сэргэлтийн бодлого” (ШСБ) нь дунд хугацааны зорилтот хөтөлбөр бөгөөд 10 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Энэхүү бодлогын зорилго нь: Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдал, өөртөө түшиглэх чадварыг бэхжүүлэх; Коронавируст халдвар (COVID-19)-ын эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөг бууруулах; Хөгжлийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шуурхай шийдвэрлэх зэрэг болно. Монгол улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.32 ШСБ-ыг хэрэгжүүлснээр Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шатны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэх юм. Эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй 6 томоохон саадыг төр, хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагаагаар шийдвэрлэхээр тусгасан. Үүнд: худалдааны боомт, эрчим хүч, үйлдвэржилт, хот, хөдөөгийн хөгжил, ногоон хөгжил, үр ашигтай засаглал зэрэг орно.

2021–2025 оны таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл

4.2.33 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “2021–2025 оны таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл” нь улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050”-тай уялдсан дунд хугацааны стратегийн баримт бичиг юм. Энэхүү баримт бичигт таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх тодорхой зорилго, зорилт, арга хэмжээг тусгасан бөгөөд улсын, салбарын, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд бодлогын уялдаа холбоог хангах зорилготой. Мөн уг үндсэн чиглэл нь: ТХЗ-уудыг бодлогын хэрэгжилтэд нэгтгэх; Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зэрэгт онцгой анхаарал хандуулсан байна.

- 4.2.34 Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилт юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг тодорхойлсон байна: Эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх; цахилгаан станцуудыг өргөтгөх, дамжуулах шугам, дэд станц барих, дотоодын цахилгаан эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах шинэ эх үүсвэр бий болгох; Нүүрс-химийн үйлдвэр, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, металлургийн үйлдвэр зэрэг хүнд үйлдвэрлэлийг байгуулах, үүний тулд төмөр зам, ус, эрчим хүч зэрэг шаардлагатай дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх; Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах тогтвортой, өөрөө зохицуулагдах системийг бий болгох

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

- 4.2.35 Энэхүү хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд хөгжлийн парадигмын шинэ чиг хандлагыг тодорхойлж, улсын нийгэм-эдийн засгийн болон орон зайн бүтцийг илүү тэнцвэртэй болгох бүсчилсэн хөгжлийг онцлон тусгасан. Шинэ бүсийн хуваарийг нэвтрүүлж, Дорноговь аймаг бусад дөрвөн говийн аймгийн хамт өмнөд буюу Говийн бүсийг бүрдүүлсэн. Говийн бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Говийн байгалийн, түүхэн, соёлын өв болон палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэн, өндөр технологийн уул уурхай болон хүнд үйлдвэрт мэргэшсэн “Үндэсний баялгийг бүтээгч бүс” болох явдал юм. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийт 39 зорилт тодорхойлогдсон бөгөөд үүнд: Дорноговь аймгийн Алтанширээ суманд нефть боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр болон дагалдах бусад үйлдвэрүүдийг барих; Нарны болон салхины цахилгаан станцуудыг тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтайгаар барих; 220 кВ-ын Чойр–Сайншандын агаарын цахилгаан дамжуулах шугам барих; 220 кВ-ын хоёр хэлхээтэй Сайншанд–Цагаан суваргын агаарын дамжуулах шугам барих, Цагаан суваргын дэд станцыг өргөтгөх; Чойр, Сайншанд хотын тээвэр, ложистикийн төвүүдэд тулгуурласан хуурай боомтуудыг байгуулах; Дорноговь аймгийн Цагаан суваргын бүсэд палеонтологийн нөөцөд тулгуурласан тусгай аялал жуулчлалын бүсийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- 4.2.36 Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Говийн бүсийг “тусгайлан үйлдвэрлэлийн бүс болон ногоон эрчим хүчний дэд бүс” гэж тодорхойлсон бөгөөд өмнөд Монгол буюу Говийн бүсэд хэрэгжүүлэх хэд хэдэн төслийг тусгасан байна:
- Сэргээгдэх эрчим хүч болон тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх
 - Нүүрс-химийн болон кокс-химийн цогцолборуудыг хөгжүүлж ашиглалтад оруулах
 - “Алтанширээт” аж үйлдвэрийн болон технологийн парк, “Гэрэлт говь” аж үйлдвэрийн болон технологийн паркуудыг бусад дагалдах үйлдвэрүүдийн хамт төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах
 - Говийн бүсэд тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай нарны болон салхины цахилгаан станцуудыг барих
 - Шинэ нар, салхины цахилгаан станцуудтай уялдуулан 200 МВт-аас дээш хүчин чадалтай дасан зохицох батерей хадгалах системүүдийг байгуулах

- Дэд станц, цахилгаан дамжуулах шугамыг өргөтгөх, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлэх, дамжуулах алдагдлыг бууруулах
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах
- Найдвартай, аюулгүй, тогтвортой эрчим хүчний хангамжийг хангахын тулд 300 МВт-аас дээш хүчин чадалтай цахилгаан станцыг Говийн бүсэд барьж ашиглалтад оруулах, эхний ээлжинд дотоодын хэрэгцээг бүрэн хангах
- Эрчим хүчний тогтвортой байдлыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зохистой хөгжүүлэх үндсэн баримт бичиг болох нэгдсэн сүлжээний код болон удирдлагын системийг байгуулах
- Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан нарны болон салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг барих
- 220 кВ-ын Багануур–Чойр, 220 кВ-ын Мандалговь–Арвайхээрийн агаарын дамжуулах шугам, дэд станцуудыг барих, мөн 220 кВ-ын Сайншанд–Цагаан суваргын агаарын дамжуулах шугам, дэд станцын төслийн бэлтгэл ажлыг хангах
- 220 кВ-ын Таван толгой–Оюу толгойн чиглэлийн агаарын дамжуулах шугам, дэд станц, мөн 220 кВ-ын Чойр–Сайншандын чиглэлийн агаарын дамжуулах шугам, дэд станцыг барих

Байгаль орчин, нийгмийн хуулиуд

Монгол Улсад байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлого, хууль тогтоомжийн шатлал нь дараах бүрэлдэхүүнтэй: Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцууд, байгаль орчин болон нөөцийн хамгаалалтын тухай хууль, холбогдох стандартууд, хүний хөгжилтэй холбоотой хууль тогтоомжууд (боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, нийгмийн хамгаалал) зэрэг болно. Төслийн хэрэгжилтэд холбогдох байгаль орчин, нийгмийн хууль тогтоомж болон зохицуулалтуудыг **Хүснэгт 4-4**-д тусган мөрдөж ажиллана.

Хүснэгт 4-4 Байгаль орчин, нийгмийн гол хуулиуд

Хуулийн нэр	Товч танилцуулга	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он
Монгол улсын үндсэн хууль	Монгол Улсын Үндсэн хууль нь төлөөллийн ардчиллыг тогтоож, төрийн үндсэн чиг үүргийг баталгаажуулсан бөгөөд эрх мэдлийн хуваарилалт, сонгуулийн мөчлөгийг багтаасан. Мөн шашин шүтэх эрх чөлөө, зорчих эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хувийн өмчийн эрх зэрэг хүний эрхийг баталгаажуулсан. 2019 онд Монгол Улс Үндсэн хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, улсын өргөн хүрээтэй байгалийн баялаг болон түүнээс олсон орлогыг хэрхэн удирдах, хянах эрхийг иргэдэд илүү олгох зорилго тавьсан.	1992	1999, 2019, 2022, 2023
Иргэний хууль	Энэ хууль нь хуулийн этгээдүүдийн хооронд үүсэх материаллаг болон материаллаг бус баялгатай холбоотой харилцааг зохицуулна. Эдгээр харилцааг зохицуулах иргэний хууль тогтоомж нь хэд хэдэн үндсэн зарчимд тулгуурладаг. Үүнд: иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдал ба бие даасан байдал, өмчийн халдашгүй дархан байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх, үүргийг	2022	Сүүлийн нэмэлт өөрчлөлтүүд 2021, 2021, 2023, 2024

Хуулийн нэр	Товч танилцуулга	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он
	чөлөөтэй хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг шүүхийн тогтолцоогоор сэргээх ба хамгаалах зэрэг зарчим багтана.		
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	<p>“Байгаль орчныг хамгаалах тухай хууль” нь 1995 оны 3 дугаар сарын 30-нд батлагдаж, 2024 онд хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хууль нь төр, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондын харилцааг зохицуулж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг баталгаажуулах, экологийн тэнцвэртэй нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, байгаль орчныг одоо болон ирээдүй хойч үед хамгаалах, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, сэргээх зорилготой.</p> <p>Хуульд хариуцлагын тогтолцоог бий болгосон бөгөөд буруутай этгээд нь үйл ажиллагаанаасаа үүдэн гарсан байгаль орчны сөрөг нөлөөлөл болон байгалийн баялгийг сэргээх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй. Мөн албан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцно гэж заасан. Үүнээс гадна аливаа үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны үнэлгээ хийлгэхээр байгаль орчны шинжээчийг томилох үүрэгтэй бөгөөд байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх торгууль ногдуулж болно.</p> <p>Байгалийн баялгийн өмчлөл болон байгаль орчны хамгаалалттай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ, тусгай зөвшөөрөл, лицензийн дагуу холбогдох төлбөрийг төлж, хураамжийг бүрдүүлэн байгалийн баялгийг ашиглаж болно (6.2 дугаар зүйл).</p> <p>Байгаль орчны аудит хоёр жил тутам хийгдэх бөгөөд аж ахуйн нэгж нь байгаль орчны аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайлангаа аудитын тайланд заасан хугацаанд аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх ёстой (10.1 дүгээр зүйл).</p>	2012 (Шинэчилсэн хувилбар)	2015, 2017. 2022, 2023, 2024
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль	<p>“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль” нь 2012 оны 5 дугаар сарын 17-нд батлагдаж, 2024 онд хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй экологийн тэнцвэргүй байдлыг урьдчилан сэргийлэх, бүс нутаг болон салбарын хүрээнд байгалийн баялгийг байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр ашиглах, хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр, дүгнэлт гаргах явдал юм. Мөн оролцогч талуудын хоорондын зохицуулалтыг хангах зорилготой.</p>	2012	2024

Хуулийн нэр	Товч танилцуулга	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он
Газрын хэвлийн тухай хууль	<p>"Монгол Улсын Газрын хэвлийн тухай хууль" нь газрын хэвлийн баялгийг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулж, эдгээр баялаг нь одоо болон ирээдүй хойч үед ашиг тусаа өгөхийг хангахад чиглэнэ. Энэ хууль нь дэд хөрсийг улсын өмч гэж тогтоож, Монгол Улсын Үндсэн хуультай нийцүүлэн өмчлөлийг өөрчлөхийг хориглодог. Хууль тогтоомжид Үндсэн хууль, Монгол Улсын Газрын хэвлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж багтах бөгөөд зөрчил гарсан тохиолдолд олон улсын гэрээ давуу эрхтэй үйлчилнэ.</p> <p>Газрын хэвлий нь хөрсний гадаргуугийн доорх орон зай гэж тодорхойлдог бөгөөд энэ гүнд орших бүх материал, геологийн объект багтана. Ашиглалтын хэлбэрээс үл хамааран бүх газрын хэвлий нь улсын өмчид хамаарах нэгэн цогц сан гэж үзнэ. Энэ цогц хууль тогтоомж нь эдгээр чухал байгалийн баялгийг үр ашигтайгаар ашиглах, хамгаалах харилцааг зохицуулахад чиглэсэн.</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь ердийн ашигт малтмал олборлох, цэвэр ус ашиглах эрхтэй бөгөөд энэ нь уурхайн эрх олголгүйгээр, харьяалах сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийн үндсэн дээр бизнесийн болон ахуйн хэрэгцээнд ашиглаж болно (18 дугаар зүйл).</p> <p>Газрын хэвлий ашиглагчдын үндсэн эрх, үүрэг (20 дугаар зүйл):</p> <p>3. Газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах;</p> <p>4. Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;</p> <p>5. Газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах.</p>	1988	2023
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	<p>"Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль" нь 2012 оны 5 дугаар сарын 17-нд батлагдаж, 2022 онд хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү хуулийн зорилго нь хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p>	2012	2022

Хуулийн нэр	Товч танилцуулга	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он
